

УЛСТӨРЧИЙН ХӨРӨГ

ӨНӨР АЙЛЫН ЭЗЭГТЭЙ

II нүүрт

ДЭЛХИЙ

ДЭЛХИЙН УДИРДАГЧДЫН ХҮҮХЭД НАС

VI нүүрт

САЙД ЯРЬЖ БАЙНА



Гэрэл зургийг Г.АРГҮҮЖИН

Дугаарын **60** мөр
Фэйсбүүк,
ТВИТТЕРТ ХЯНАЛТ
ХЭРЭГТЭЙ БАЙНА
Э.ТУУЛ

МОНГОЛ-ДЭЛХИЙН ХЭВЛЭЛД

САРЛАГИЙН МАХ ДУУЛИАН ДЭГДЭЭЖ, ЖОН КЕРРИГИЙН АЙЛЧЛАЛ АНХААРАЛ ТАТАВ

Б.ДАВАА

“Монголын мэдээ” сонин дэлхий дахин манай улсыг аль талаас нь сонирхож, хэрхэн мэдээлж буйг онцлон орчуулан уншигчиддаа хүргэдэг уламжлалтай. Энэ удаа Монголын эдийн засаг, Эгийн голын Усан цахилгаан станц хийгээд Швейцарийн нисэх онгоцны буудалд борц авч очсон монгол эмэгтэйн талаарх мэдээлэл дэлхийн хэвлэлд хэрхэн бичсэнгийг тоймлон хүргэж байна. Монгол Улсын хувьд өнөө жил АСЕМ-ийн дээд хэмжээний уулзалт зохион байгуулах учраас энэ талаар дэлхийн хэвлэл мэдээлэл илүүтэй анхаарал хандуулж буй. Мөн Эгийн голын усан

цахилгаан станц барих тухай асуудал болон Оюутолгойн далд уурхайн бүтээн байгуулалт өнөө хэр моодноос гараагүй сэдэв хэвээр байгаа юм.

Казахстан, Монголын эдийн засгийн өрсөлдөх чадварын рейтинг буурлаа

“ca-news.org” сайтнаа дэлхийн улс гүрний эдийн засгийн өрсөлдөх чадварыг харуулсан сонирхолтой мэдээлэл нийтэлжээ. Гэхдээ мэдээлэлд Казахстан, Монголыг онцлох байх аж.

Үргэлжлэл нь III нүүрт

Улаанбаатарт: ӨНӨӨДӨР

Өдөр +29
Шөнө +12

Үргэлжлэл нь III нүүрт

ДУГААРЫН СУРВАЛЖЛАГА



Төслийн удирдагч П.Цагаан хурлыг удирдаж

ЕТГ-ЫН ДАРГА П.ЦАГААН: Хадны зураг бол бүхэл бүтэн номын сан

Сэтгүүлч Б.ӨНӨРТОГТОХ

Монгол Улсын Ерөнхийлөгч, ЮНЕСКО-ийн ивээл дор “Хаданд мөнхөлсөн урлаг: Түүх, ойлго, ярилцаан” сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний хурал, экспертүүдийн уулзалт тавдугаар сарын 30, 31-нд “Туушин” зочид буудалд боллоо. Монгол түмний түүхэн өв соёлын нэг болох хадны зургийг хамгаалах, бүртгэлжүүлэх, мөн хадны зураг судалдаг эрдэмтэн судлаачдын анхаарлыг татах зорилгоор зохион байгуулсан энэхүү эрдэм шинжилгээний хуралд дэлхийн таван тивийн, 10 гаруй орны эрдэмтэн судлаач, дотоодын 100 гаруй эрдэмтэн оролцож, өөрсдийн улс орнууд болон Монголын Хэнтий, Хангай, Саяны их уулс, Баян-Өлгий, Хөвсгөл, Увс, Дорнод зэрэг 21 аймаг, 360 гаруй суманд буй хадны зураг, буган чулуун хөшөөний түүхэн өв соёлын талаар хийсэн судалгааг танилцуулж, улмаар сонирхолтой илтгэл хэлэлцүүлэв. Олон улсын хурлыг Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж

нээж үг хэлэхдээ, дэлхийн хэмжээний эрдэм шинжилгээний хурал нь хадны зургийг хамгаалах, хайрлах талаар амь амьдралаа зориулж яваа хүмүүсийн хувьд томоохон баяр юм гэв. Тэрбээр, “Би Алтайн өндөр ууланд төрж, хөлд орсон хүн. Багаасаа хадны зургийг сонирхож, гайхаж, энэ орчлонтой танилцсан. Эхээс унахдаа л бараг ийм гайхамшигтай бүтээл, хадны галарей дотор төрсөн, хөлд орохдоо л энэ галарей дундуур мөлхөж өссөн улсуудын хувьд бид олон орны эрдэмтэд, манай судлаачид цуглаад энэ тухай ярьж байгаад баяртай байна” хэмээлээ. Хадны зургийг хамгаалах, бүртгэлжүүлэх төсөл хоёр жилийн өмнөөс эхэлж, улмаар Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга, Балар болон Өнө эртний судлалын Олон улсын нийгэмлэгийн гишүүн П.Цагааныг төслийн удирдагчаар ажиллаж, хоёр жилийн хугацаанд чамгүй олон ажлыг амжуулсан аж.

Дэлгэрэнгүйг IV нүүрнээс

ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ

Бөөрөлжүүтийн талд 600 мегаватт хүчин чадалтай цахилгаан станц барина

Бөөрөлжүүтийн нүүрсний уурхай, цахилгаан станцын цогц төслийн Хөрөнгө оруулалтын гэрээ, Цахилгаан эрчим хүч худалдах худалдан авах гэрээнд гарын үсэг зурах ёслолын арга хэмжээ өнгөрөгч мягмар гарагт Төрийн ордонд боллоо. Монголчууд бизнест эргэн ирж, хөрөнгө оруулалт сэргэж буйн нэгэн бодитой жишээ, сайн мэдээ, сайн үйл явдлын нэг нь Бөөрөлжүүтийн цахилгаан станцын төсөл болж байна. “Бодь интернэшл” групп, “Цэцэнс майнинг” компани байгуулж, таван жилийн өмнөөс Бөөрөлжүүтийн талын

хүрэн нүүрсний ордод түшиглэн 600МВт-ын хүчин чадалтай иж бүрэн цогц төслийг эхлүүлсэн нь ийнхүү нэг тэрбум долларын шууд хөрөнгө оруулалт, бодит ажил болж байна. Найман сарын өмнө БНХАУ-ын Далянь хотод болсон Эдийн засгийн Зуны чуулганд оролцох үеэр энэхүү төсөлд хөрөнгө оруулах хамтын ажиллагааны гэрээнд Монголын “Бодь интернэшл” болон Хятадын “Пауэрчайна Ресурсэс” компани гарын үсэг зурж байсан нь ийнхүү эдийн засагтаа ч гэрэл, эрч хүч нэмэх бодитой шатандаа орлоо гэж Ерөнхий сайд Ч.Сайханбилэг

тус арга хэмжээнд оролцохдоо хэллээ. 600 МВт-ын хүчин чадалтай Дулааны цахилгаан станц, 70 км урттай хос хэлхээт 220 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугамтай, жилд гурван сая тонн нүүрс олборлох хүчин чадал бүхий уурхайн ажил Монголд гэрлийн, валютын өргөн урсгал нэмэх болно. Монгол бол хөрөнгөө оруулахад таатай, дэлхийдахинд эрэлт хэрэгцээтэй эрчим хүч, энергийн арвин их баялагтай, хууль, эрх зүйн орчин нь улам сайжирч буй орон.

Төгсгөл нь III нүүрт

Тун удахгүй
Лавхар лавхар сюрприз

MINFO

ХААН Банк				Худалгаа хөгжлийн банк				
	Авах	Зарах		Авах	Зарах		Авах	Зарах
АМ.ДОЛЛАР	1992.00	2003.00	ФУНТ	2833.00	2914.00	АМ.ДОЛЛАР	1993.00	2004.00
ЕВРО	2215.00	2267.00	РУБЛЬ	28.20	32.00	ЕВРО	2216.00	2278.00
ИЕН	17.68	18.09	ЮАНЬ	306.00	308.80	ИЕН	17.71	18.23
						ФУНТ	2848.00	2922.00
						РУБЛЬ	29.02	31.51
						ЮАНЬ	305.90	309.00

Өчигдрийн 19.00 цагийн байдлаар

УЛС ТӨР

УЛСТӨРЧИЙН ХӨРӨГ

ӨНӨР АЙЛЫН
ЭЗЭГТЭЙ

Ч.ЧУЛУУНЦЭЦЭГ

Монгол Улсын нийслэлд өнөөдөр сая гаран хүн ажиллаж, амьдарч байгаагийн 140 гаруй мянга нь Сүхбаатар дүүрэгт хамааралтай гэхээр өнөр өтгөн айлтай зүйрлэж болохоор. Их айлын үүд өдөржин нээлттэй онжино. Хүүхдүүд нь орж гараад л. Эцэг, эх хоёрын хэн нь ч хаалга үүдээ онголууллаа хэмээн зэмлэхгүй. Харин ч эдний маань сураг л дуулдаж байвал боллоо гэсэн шиг амар амгалан сууцгаах. Хөвгүүд нь өсч, охид нь айлын болцгоосон ч эцэг, эхээ хормойдон хошуугаа унжуулах нэгэн ч байна. Амьдралд хөл алдан туйлдаж, өмөг түшиг эрэх хүү ч бий, охин ч байх. Үрс нь юм хойно, тэднийгээ ялгах сэтгэл эцэг, эхэд үгүй юм хойно, болж яваагаас нь авч бүтэлгүйдээ өгнө. Заримдаа ижийд нь хэрэг болоод байна хэмээн заль хэрэглэж байгаад ч болов нөгөө хүүгийнхээ хэргийг бүтээх. Хүний хорвоогийн амьдрал ингэж л буцалдаг. Дүүрэг ч ялгаагүй. Аль нэг хэсэгт бүтээн байгуулалт өрнөн, иргэд нь шинэ орон сууц руу нүүн аз жаргалдаа умбаж байхад нөгөө нь мөнөөх л 30 жилийн түүхтэй хашаандаа, Гэр хорооллын дахин төлөвлөлт хэзээ хаалга тогшихыг хүлээж цохно. Арга барсан нь дүүрэг рүүгээ харайна. Азаар хүлээж авах албан тушаалтнууд нь тодорхой юм даа. Гэвч иргэдийн санаа амрахгүй. Өөрийг нь хамгийн сайн сонсох хүнийг л эрэлхийлнэ. Зарим нь Засаг даргын орлогчийг л бүсгүй хүнийг зовлон мэдэх юм гээд онцлолж уулзахыг хичээнэ. Мэдээж тэр нь Х.Болормаа дарга. Ер нь түүнийг сүхбаатарчууд анддаггүй. “Манай Болормаа дарга” хэмээн өмчлөх хороо ч бий, хэсэг ч бий, хөгшчүүд ч байна. Үнэндээ тэрбээр амьдралынхаа багагүй хугацааг, СБД түүн дотроо XI, XII, XIII хорооны иргэдийн сайн сайхны төлөө зориулж яваа нэгэн. Жаргал зовлонгоос нь хуваалцаж явсан, эдүгээ ч тэдэнтэйгээ, тэднийхээ дунд бужигнаж яваа болохоор арга ч үгүй биз. Дүүрэг дэх өрөөнийх нь хаалга онгоглохгүй, хүний хөлд дарагдахгүй өнжих өдөр гэж үгүй. Тэр л жижигхэн өрөөнд дүүргийн 140 гаруй мянган иргэний амьдрал ямар нэг байдлаар буцална. Баяр баясгалангаа Х.Болормаа даргадаа дуулгах гэсэн нэгэн байхад оршуулгын зардал өгөөч гээд зогсох иргэн байж л байна. Хамгийн гол нь тэрбээр хэзээ ч хэнийг ч төвөгшөөж байгаагүйд хэргийн учир оршино. Ер нь Х.Болормаа дарга хүүхэд байхын ийм байсан. Тэдний оронд хоёр өндөр настан, нэг хөгжлийн бэршээлтэй иргэн амьдардаг байж. Өглөө босоод үүрэг юм шиг өнөөх гурван айлаараа орж, сүү авах бидон эсвэл махных нь мөнгөөд аваад дэлгүүрийн зүг нисчихнэ. Тухайд үед мах, сүү өнөөдөртэй адил элбэг дэлбэг байгаагүй. Тархин дээгүүр гурав, таван литрийн бидонууд “зодолдож”, дугаарлаж зогсох багачуудыг томчууд түрээд гаргачих юу ч биш. Нүүрээ улайтал зүтгэсэн бяцхан Болормаа тэр дундаас сүү, махаа тэвэрсээр гарч ирэх.

АЙЛЧЛАЛ

УИХ-ын дарга З.Энхболд Японд
айлчилж байна

Б.ЭРХЭС

УИХ-ын дарга З.Энхболд Япон Улсад ажлын айлчлал хийхээр мордлоо. Түүний ажлын айлчлал өчигдөр эхэлсэн бөгөөд өнөөдөр, маргааш хоёр өдөр үргэлжлэх юм. Ажлын айлчлалын үеэр УИХ-ын дарга З.Энхболд Япон Улсын Парламентын Төлөөлөгчдийн танхимын дарга Т.Ошима, Зөвлөхүүдийн Танхимын дарга М.Ямазаки, Ерөнхий сайд Шинзо Абе нартай уулзана. Мөн тэрбээр Монгол Улсын Хөдөлмөрийн яам, Япон Улсын Эрүүл мэнд, хөдөлмөр, нийгмийн халамжийн яам хоорондын “Хөдөлмөрийн салбар дахь хамтын ажиллагааны санамж бичиг”-т гарын үсэг зурах ёслолд оролцоно. Уг санамж бичигт гарын үсэг зурснаар Монгол, Япон Улсууд харилцан тохиролцож ажиллах хүч илгээ, хөдөлмөр эрхлэлт, ур чадвар дээшлүүлэх мэргэжлийн боловсролын сургалтад манай улсын дадлагажигчид хамрагдах цар хүрээ өргөжин, баталгаажих юм. Өнөөдрийн байдлаар Монгол Улсаас Япон Улсад 1,500 гаруй дадлагажигч ажиллаж байна. Түүнчлэн Монгол Улсын Уул уурхайн яам, Япон Улсын Эдийн засаг, худалдаа, аж үйлдвэрийн яам хоорондын “Цэвэр нүүрсний технологийн солилцоог дэмжих хамтын ажиллагааны санамж бичиг”-ийг үзэглэнэ. Ингэснээр Монгол Улсад үр ашгтайн нүүрсний хэрэглээг дэмжих зорилгоор цэвэр нүүрсний технологийн солилцоог гүнзгийрүүлэх, хамтарсан судалгааг дэмжих, нүүрс хийжүүлэх технологи болон хагас кокжсон шахмал түлшний үйлдвэрлэлийн төсөл хэрэгжүүлэх зэргээр хоёр улс хамтран ажиллах боломж бүрдэнэ. УИХ-ын дарга ажлын айлчлалынхаа хүрээнд Япон Улсын Фукушима муж дахь нүүрснээс хий гаргаж, эрчим хүч, дулаан үйлдвэрлэх шинэ технологийг /IGCC/ нэвтрүүлсэн “Накасо” дулааны цахилгаан станцын үйл ажиллагаатай танилцана. Мөн Чива мужийн полипропилен буюу бүх төрлийн шластмассан бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг “Прайм Полимер” компанид зочлох юм. Тус компани нь полипропилен түүхий эдээр машины эд анги болон бусад полипропилен бүтээгдэхүүнийг үйлдвэрлэдэг байна. УИХ-ын дарга Сайтама мужийн Шибасакү үйлдвэрт зочлон, тус үйлдвэрт дадлагажигчаар ажиллаж буй монгол иргэдтэй уулзах аж. айлчлалын бүрэлдэхүүнд УИХ-ын гишүүн, Хөдөлмөрийн сайд Г.Баярсайхан, Уул уурхайн сайд Р.Жигжид, УИХ-ын даргын зөвлөх Ц.Буянцогтоо, Б.Баярсайхан болон албаны бусад хүмүүс багтжээ.

...Тэр бас бусдын адил ганзага үүрч, амьдралаа босгосон ижий бурхан. Монгол Улс зах зээлийн эдийн засагт шилжсэн он жилүүдэд залуу хосууд эзэмшсэн мэргэжлийнхээ дагуу компани байгуулан, улсынхаа хөгжил цэцэглэлтэд чадлынхаа хэрээр хувь нэмрээ оруулсан бизнесмэн...

Өнөө цагт бол хэн ч тийм дараалал руу хүүхдээ илгээхгүй л болов уу. Харин тэр бусдад туслах чин хүсэл, тусархуу зандаа хөтлөгдөн томчуудын дундуур зүсч ороод л санаснаа гүйцээх. Үүнийг хүнлэг сэтгэл, дайчин чанар ч гэж ойлгож болохоор. Энэ бүх сайхан чанарыг тэрбээр аваасаа өвлөсөн гэнэ билээ. Удам угсаа нь ч тийм юм билээ.

Х.Болормаа дарга авынхаа талыг хөөх аваас Увс аймгийн Өндөрхангай сум, эхийн талаараа Говь-Алтайн Төгрөг сумынх болоод явчихна. Хүний хорвоод дуугаа хадаан мэндэлсэн газар нь Сэлэнгэ аймгийн Мандал сум буюу олны нэрлэж заншсанаар Зүүнхараа хот. Хүүхэд нас нь нийслэлийн СХД, Таван шарын таван шар байрны хүүхдийн тоглоомын талбай, арван жилийн XII дунд сургуульд өнгөрсөн. Тэр даргын охин. Найман хүүхэдтэй өнөр өтгөн айлын тав дахь нь. Цагдаагийн дэд хурандаа Ө.Хөххүү агсан охин шигээ гялалзсан түргэн хөдөлгөөнтэй, бусдын сайн сайхны төлөө оюун бодол, сэтгэл зүрхээ зориулсан нэгэн байсан юм. Тагнуул, Цагдаа гээд хууль сахиулах байгууллагад хэсгийн төлөөлөгчөөс газар, хэлтсийн даргаар олон жил ажилласан энэ эрхмийг салбарынхан нь эдүгээ ч хүндтэн дурсаар байдаг. Ижий нь ч мөн л дарга. Төмөр замын хүүхдийн секторын фондын даргаар ажилласан Содномын Баянзулыг хүүхдийн байгууллаагынхан андахгүй. Түүний аав Содном агсан Говь-Алтай аймгийн Төгрөг сумын анхны даргаар ажиллаж байсан тухайн үеийн шилдэг сэхээтнүүдийн нэг байв. Харин эдүгээ түүний зээ охин Х.Болормаа Засаг даргын орлогч бөгөөд үндсэн мэргэжил нь нийтийн хоолны технологич инженер. Тэр бас бусдын адил ганзага үүрч, амьдралаа босгосон ижий бурхан. Монгол Улс зах зээлийн эдийн засагт шилжсэн он жилүүдэд залуу

МЭДЭЭЛЭЛ

НӨАТ-ын урамшууллыг жилд хоёр удаа
олгохоор болжээ

УИХ-ын даргад Засгийн газрын нэр бүхий гишүүд хуулийн төсөл өргөн мэдүүллээ. Тодруулбал, Сангийн сайд Б.Болор НӨАТ-ын тухай хуульд өөрчлөлт оруулах, Энэтхэг улсаас авах нэг тэрбум ам.долларын зээлийн хэлэлцээрийг соёрхон батлах, Хөгжлийн банкны тухай хуульд өөрчлөлт оруулах асуудлыг тус тус өргөн мэдүүллээ. Харин ЭМС-ын сайд С.Ламбаа Эмч эмнэлгийн ажилтнуудын даатгалын тогтолцоог бий болгох асуудлыг хэлэлцүүлэхээр өргөн барьжээ. Тодруулбал, НӨАТ-ын урамшууллын олголтыг жилд нэг байсныг хоёр удаа олгохтой холбогдох харилцааг зохицуулах аж. Мөн албан татвар төлөгчид нэмэгдсэн өртгийн албан татварын буцаан олголтыг энэ жил олгохын тулд эх үүсвэрийг Монгол Улсын 2016 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах замаар тусган шийдвэрлэх шаардлага бий болжээ. Татварын албаны цахим төлбөрийн баримтын системд 2016 оны нэгдүгээр улирлын байдлаар 31758 аж ахуйн нэгж, иргэн бүртгүүлсэн, 38310563 баримт хэвлэгдсэн, 15771545 баримт баталгаажсан үзүүлэлттэй байгаа аж. Нийт 5216 албан татвар төлөгч иргэн НӨАТ суутган төлөгч аж ахуйн нэгжээс 385 тэрбум төгрөгийн худалдан авалт хийсэн, нэмэгдсэн өртгийн албан татварын 20 хүртэлх хувийн буцаан олголтоор нь 5.8 тэрбум төгрөг авахаар юм байна. Мөн УИХ-аас 2011 онд Монгол Улсын

Хөгжлийн банкны тухай хуулийг баталж, уг хуулиар Хөгжлийн банкны үйл ажиллагааны эрх зүйн үндэс бий болсон. Хуулийн төсөлд Хөгжлийн банкны хувь нийлүүлсэн хөрөнгийг нэмэгдүүлэх чиглэлээр тус банкны өөрийн хувь нийлүүлсэн хөрөнгийг нэмэгдүүлэх, хувьцаа эзэмшигчдийн шийдвэрээр шаардлагатай тохиолдолд нэмэлт хувьцаа гарган, хувийн өмчит хуулийн этгээдэд худалдаж болох талаар зохицуулалт тусгажээ. Мөн банкны засаглалыг сайжруулах чиглэлээр төлөвлөн удирдах зөвлөлийн эрх, үүргийг нарийвчлан тусгасан байна. Энэхүү хуулийн төсөл батлагдсанаар тэргүүлэх болон стратегийн ач холбогдол бүхий салбарууд болон уул уурхай, дэд бүтэц, аж үйлдвэрийн томоохон төслүүдийг шуурхай хэрэгжүүлэх нөхцөл бүрдэхийн зэрэгцээ цаашид эдийн засгийн өсөлтийг хангах ядуурлыг бууруулах, иргэдийн ажлын байр, тогтмол орлогын эх үүсвэртэй болгоход чухал нөлөө үзүүлнэ гэж төсөл санаачлагч үзжээ. Харин С.Ламбаа сайдын өргөн мэдүүлсэн Эмнэлгийн мэргэжилтний хариуцлагын даатгалын тухай хуулийн төслийг цаашид үл маргах зарчмаар эвлэрлийн гэрээнд тулгуурлан нөхөн төлбөр олгох, хэрэв иргэн үүнийг үл зөвшөөрч хуулийн байгууллагад хандсан бол шүүхээс тогтоосон хохирын хэмжээгээр нөхөн төлбөр олгох гэсэн хоёр үе шаттай байхаар боловсруулжээ.

Н.Энхбаяр төрийн эрх
авах гэж өлссөн үү

Б.ТОГТОХ

МАХН-ын дарга Н.Энхбаяр өлсгөлөн зарлан улс төрийн шоу хийж , улмаар хүч түрж сонгуульд оролцох гэж байгаа тул дүүрэг бүрийн төлөөлөл болсон 40 гаруй МАХН-ын гишүүн намаасаа гарч байгаагаа мэдэгдлээ. Тэд: “Иргэн бүр Үндсэн хуулиар олгогдсон сонгогдох, сонгох эрхээ дөрвөн жилд нэг удаа эдэлдэг. Гэтэл улс төрийн ууган хүчний нэг МАХН ард түмнийхээ сонгох эрхэнд ноцтой халдаж байна. Учир нь иргэд төр түшиллэх хүнээ хуулийн дагуу сонгуулийн аргаар сонгох ёстой. Гэтэл Н.Энхбаяр өлсгөлөнгөөр сонгуульд орох эрх олж авч, тэмцлийн хурц хэлбэрийг сонгож 66 цаг намын гишүүдээ өлсгөлөө. Өнөөдөр Монголчуудын амьдрал доройтож ард түмэн амьжиргаагаа залгуулж чадахгүй өлсөж байхад МАХН-ынхан төрийн эрхийг авахын төлөө өлслөө. Өлсгөлөн зарлана гэдэг 1990-д онд ардчилал авчирсан түүхэн сонголт байсан. Тэр сонголтээр Монголын ард түмэн өнөөдрийн сонгох, сонгогдох эрхээ олж авсан. Харин өнөөдрийн Н.Энхбаярын өлсгөлөн ард түмний ард түмний олж авсан эрх чөлөөнд халдаж байна. Өлсгөлөн бол тэмцлийн хурц хэлбэр. Зөвхөн өөрийн эрх ашгийн төлөө намын гишүүдийн амь насанд халтай тэмцлийн хурц хэлбэрийг сонгож, МАХН-аас нэр дэвшиж байгаа л бол өлсгөлөнд оролцох ёстой гэж хүмүүсийг хүчлэн өлсгөлөнд оролцуулснаас болж хэд хэдэн хүний биеийн байдал муудаж, өлсгөлөнгөө зогсоолоо. Төрийн эрх мэдлийг авахын төлөө хүний амь насар дэнчин тавьж болохгүй. Бусдыг өлсгөлөн уриална гэдэг эрүүгийн гэмт хэрэгт тооцогддог. МАХН сонгуулиа өлсгөлөнгөөр эхлүүлж байгаа нь сайны ёр биш” гэв.

minfe.mn
МОНГОЛЫН МЭДЭЭ
18 дахь жилдээ

Ерөнхий эрхлэгч: С.ГАНТОГОО

Орлогч эрхлэгч: Ч.ЧУЛУУНЦЭЦЭГ 99189158

Хариуцлагатай нарийн бичгийн дарга: Э.ЭНХЦЭЦЭГ 88873012

Ахлах редактор: Б.ӨНӨРТОГТОХ 88006842

Шуурхай мэдээлэл, эрэн сурвалжлах алба: Н.ПУНЦАГБОЛД 88096454

Улс төр, гадаад мэдээлэл, эдийн засгийн алба: Б.ӨНӨРТОГТОХ 88006842

Гэрэл зургийн алба: Г.АРГУУЖИН 96017873

Компьютерийн алба: Б.ГАНЗОРИГ 99998796

Маркетинг, зар сурталчилгааны алба: Н.АЛТАНЦЭЦЭГ 99173710

Захиалга, борлуулалтын алба: М.ДАВААДУЛАМ 99042510

Э.САЙНЗАЯА 99197866

Дугаарыг эрхлэсэн Б.ӨНӨРТОГТОХ

Улсын бүртгэлийн дугаар: 907300528
Индекс: 100757

Редакцийн хаяг: Улаанбаатар хот. Сүхбаатар дүүрэг. Чөлөөт хэвлэл сан /Хэвлэлийн хүрээлэн/. 2 давхар. 209, 211 тоот

Харилцах утас, факс: 976-70113551

“Монголын мэдээ” сонин
редакцид эхийг бэлтгэж,
“Чөлөөт хэвлэл сан”-ийн хэвлэх үйлдвэрт хэвлэв.

ҮЗЭЛ БОДОЛ

МОНГОЛ-ДЭЛХИЙН ХЭВЛЭЛД

САРЛАГИЙН МАХ ДУУЛИАН ДЭГДЭЭЖ, ЖОН КЕРРИГИЙН АЙЛЧЛАЛ АНХААРАЛ ТАТАВ

Үргэлжлэл.
Түрүүч нь I нүүрт

Уг мэдээллийг хөрвүүлбэл, “... Швейцарийн менежментийн хөгжлийн хүрээлэн дэлхийн эдийн засгийн өрсөлдөх чадварын рейтингийг гаргалаа. Үүнээс үзэхэд, Казахстан, Монгол хоёр улсын эдийн засгийн өрсөлдөх чадвар өмнөөсөө буурсан үзүүлэлтэй байна. Тодруулж хэлбэл, өрсөлдөх чадварын рейтингээрээ өнгөрсөн жил 34-т жагсч байсан Казахстан 14 байраар ухарч, 47-д бичигдсэн нь эдийн засгийн маш том уналтыг харуулж байгаа юм. Харин Монгол Улсын хувьд гурван байраар


ухарч, 57-оос 60-рт бичигдэж байна. Энэ удаагийн өрсөлдөх чадварын зэрэглэлийг гаргахдаа ДНБ өөр өөр төвшний дэлхийн 61 улсыг хамруулж, нийт 5400 судалгаанд үндэслэн гаргажээ. Харин уг үзүүлэлтийг Хонконг тэргүүлж, Швейцарь удаалсан бол гурван жилийн турш тэргүүлж байсан АНУ манлайлагчийн байр сууриа алдаж, гуравдугаарт эрэмбэлэгдлээ. Эдийн засгийн өрсөлдөх чадвараараа тэргүүлэх топ-10 улсад Сингапур, Швед, Дани, Ирланд, Нидерланд, Норвеги, Канад багтаж байгаа юм. ОХУ-ын хувьд өрсөлдөх чадвар сайжирч, 45-аас 44 болж дэвшсэн бол Венесуэл урьдын адил сүүл мушгилаа...” гэжээ.



Сарлагийн мах Шинэ Зеландын эдийн засагт 16 сая ам.долларын хохирол учруулах уу

“4-traders.com” гэх сайтнаа Монгол эмэгтэй Шинэ Зеланд руу үхрийн мах, бяслаг авч очиж, нисэх онгоцны буудлын шалган нэвтрүүлэх хэсэгт нэлээд асуудал үүсгэсэн тухай мэдээллийг нийтэлжээ. Өнгөрсөн долоо хоногт Аукландын нисэх онгоцны буудалд газардсан нэгэн эмэгтэйн тээшнээс шинэ зеландчуудын өмнө нь үзэж харж байгаагүй өвөрмөц хүнсний бүтээгдэхүүн гарч ирсэн гэнэ. Түүнчлэн эмэгтэй огт англи хэлээр ярьж чадахгүй байсан нь нисэх буудлынханд эргэлзээ төрүүлсэн байх юм. Тэгвэл тус эмэгтэйн охины хэлж буйгаар тээшинд нь сарлагийн борц, бяслаг байжээ. Аукландын нисэх онгоцны буудлын

менежер Дэйв Симс “Тэр эмэгтэй хаа байсан Монголоос авчирсан байсан. Гэхдээ шинэ Зеланд руу нэвтрүүлэх боломжгүй” гэж ярьжээ. Тэдний хувьд уг хүнс нь Шинэ Зеландын эдийн засагт ноцтой хохирол учруулж болох олон төрлийн малын халдварт өвчний нян тэеж байж болзошгүй гэж үзсэн байна. Мөн нисэх буудлын менежер “Монголын мал сүрэг олон төрлийн малын гаралтай өвчнөөр өвчилж байгаа. Энэ аюул Шинэ Зеландад нүүрлэхийг бид хүсэхгүй байна. Шинэ Зеландын эдийн засагт 16 сая ам.долларын хохирол учруулж болзошгүй” гэж хэлсэн тухай тус сайтнаа бичжээ.



Губернатор: Россия может помочь Монголии в строительстве АЭС вместо ГЭС на Селенге

Сибирь 27 мая, 8:26 | УЦС-3

Как заявлял ранее глава Минприроды РФ, ГЭС на Селенге не будет построена из-за негативного отношения к проекту со стороны международного сообщества

© Игорь Аленко/TASS, архив

ИРКУТСК, 27 мая. /ТАСС/. Россия готова оказать помощь Монголии в строительстве новых генерирующих мощностей, либо в виде ТЭС, либо АЭС, вместо строительства Шуранской ГЭС на Селенге. Об этом сообщил журналистам губернатор Иркутской области Сергей Левченко со ссылкой на решения российско-монгольской межправительственной комиссии.

*Мы проговорили этот вопрос с председателем комиссии (главой Минприроды РФ Сергеем Донским - прим. ТАСС). Он поддержал нашу инициативу - чтобы мы предложили монгольской стороне построить другую энергогенерацию на выбор: либо

ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ

БӨӨРӨЛЖҮҮТИЙН ТАЛД 600 МЕГАВАТТ ХҮЧИН ЧАДАЛТАЙ ЦАХИЛГААН СТАНЦ БАРИНА

Ургэлжлэл
Түрүүч нь I нүүрт


Шийдлийн Засгийн газар хөрөнгө оруулалт, бизнест саад болж буй элдэв чөдөр тушааг тайлахын төлөө шийдэж шинэчилж, эрх зүйн орчноо ээлтэй болгож, суурь хуулиудаа санаачлан батлуулж, хувийн хэвшлийн бүтээлч санаачилгуудыг дэмжиж түншлэн ажиллаж байна. Эрчим хүч, эрдэс баялгийн эх үүсвэрийн арвин их нөөцтэй Монгол Улс бусдаас гэрэл, цахилгаан гуйхгүй болох төдийгүй өртөг нэмж, үнэ цэнийг нь өсгөн экспортолж эхлэх нь манай үеийнхний хийх ёстой ажил, биелүүлэх учиртай даалгавар, хүрэх ёстой зорилго. Улаанбаатар хотоос 120 км зайд орших Бөөрөлжүүтийн ордыг түшиглэсэн цогц төсөл нь байршил, дэд бүтэц, хэрэглэгчдэдээ ойрхон, байгаль орчинд ээлтэй зэрэг олон давуу талтай. 2019 оноос жилдээ 1.6 тэрбум кВт.цаг



Жон Керри уламжлалт фестивалд оролцоно

АНУ-ын төрийн департаментын албан ёсны вэб хуудаснаа Төрийн нарийн бичгийн дарга Жон Керри Монголд айлчлах тухай мэдээлэл нийтлэгдсэн байв. Үүнд “...АНУ-ын Төрийн нарийн бичгийн дарга Жон Керри зургадугаар сарын 2-8-ны өдрүүдэд Францын Парис, Монголын нийслэл Улаанбаатар, Хятадын Бээжин хотноо ажлын айлчлал хийнэ. Тодруулбал, тэрбээр энэ сарын 2-4-ний хооронд Парис хотноо айлчилж, Ойрхи Дорнодод энх тайвныг тогтоох асуудлаар тус улсын албаныхантай хэлэлцэхээс гадна Гадаад хэргийн

сайд Жан Марк Аяролттай уулзаж, Сири, Иракт “Лалын улс” бүлэглэлийн эсрэг тэмцэж буй цэргийн эвслийн үйл ажиллагаанаа талаар ярилцана. Үүний дараа Монголын нийслэл Улаанбаатар хотноо айлчилж, Засгийн газрын холбогдох албаныхантай уулзана. Тус хотод тэрбээр Монголын үндэсний уламжлалт соёлын фестивалд оролцож, хотын залуу удирдагчидтай уулзахаар төлөвлөсөн...” гэжээ. Дэлхийн нөлөө бүхий удирдагчдын нэг болох түүний энэ удаагийн айлчлалыг дэлхий нийтийн анхаарлыг татаж байна.



4-Traders Homepage > News

Ministry for Primary of New Zealand : No entry for yak meat



АЦС барихад нь Оросын тал туслахад бэлэн

ОХУ-ын “Tass” агентлагийн цахим хуудаснаа дээрх мэдээлэл тавигджээ. Үүнд “...Шүүрэнгийн УЦС-ыг барихын оронд ДЦС болон АЦС барихад нь Монголд туслахад Оросын тал бэлэн байна. Энэ тухай Эрхүү мужийн захирагч Сергей Левченко Орос-Монголын Засгийн газар хоорондын комиссын шийдвэрийг иш татан мэдэгдлээ. “Бид энэ асуудлыг Байгалийн нөөц, экологийн сайд бөгөөд тус комиссыг даргаллагч Сергей Донскойтой ярилцсан. Монголд байдаг сайн чанарын нүүрсээр ажиллах хэд хэдэн дулааны цахилгаан станц /ДЦС/ эсвэл атомын цахилгаан станц /АЦС/ барихыг Монголын талд санал болгоё гэсэн бидний санаачилгыг сайд дэмжлээ” гэж С.Левченко ярьсан юм. Сайд С.Донской өмнө нь мэдэгдэхдээ “Дэлхийн хамтын нийгэмлэгийн зүгээс Сэлэнгэ мөрөн дээр УЦС барих асуудалд сөргөөр хандаж байгаа, мөн Орос улс үүнийг эсэргүүцэж байгаа учраас энэ төслийн экологийн үнэлгээ хийгдэхгүй, УЦС баригдахгүй” гэж байв. Түүний хэлснээр, Монголд эрчим хүчний хэрэгцээ

шаардлага бий гэдгийг ОХУ ойлгож байгаа бөгөөд өөр бусад хувилбарыг санал болгоход бэлэн байгаа аж. Харин Эрхүү мужийн захирагчийн үзэж байгаагаар, Сэлэнгэ мөрөн дээр УЦС барих гэсэн Монголын байр суурь нь Оросын талыг эрчим хүчний тарифаа буулгахад хүргэх зорилготой мэт харагдаж байгаа ажээ. Тэрбээр хэлэхдээ “Экологийн шаардлагаас үүдэн Шүүрэнгийн УЦС-ыг барих магадлал бага. УЦС-аас эрчим хүч гарган авахын тулд Монголын нутгийн талыг нь усанд живүүлэхэд хүрнэ” гэсэн байна. Монголын тал Байгаль нуурт цутгадаг Сэлэнгэ мөрөн болон түүнд цутгадаг голууд дээр хэд хэдэн УЦС барихаар төлөвлөж байгаа юм. Сэлэнгэ мөрөн нь Байгаль нуурын усны 80 хувийг хангадаг билээ...” гэжээ. Сэлэнгэ мөрөн болон түүнд цутгадаг голууд дээр манай улс хэд хэдэн усан цахилгаан станц барихаар төлөвлөсөн. Гэвч ОХУ-ын зарим экологичид уг асуудлыг эсэргүүцэж буй юм. Тэдний хувьд усан цахилгаан станцуудыг барьснаар Байгаль нуур ширгэхэд хүрнэ хэмээн эмээж буй.

ВУРАХ ЁСЛОЛ ТӨРИЙН ОРДОН | 2016.05.31



Цахилгаан эрчим хүч худалдах худалдан авах гэрээнд худалдан авагчийн төлөөлөн “Диспетчерийн Үндэсний Төв” Төрийн өмчит компанийн Гүйцэтгэх захирал Х.Цогтбаатар, Цахилгаан Дамжуулах Үндэсний Сүлжээ Төрийн өмчит хувьцаат компанийн Гүйцэтгэх захирал

Г.Занданхүү, худалдагч талыг төлөөлөн Цэцэнэ Майнинг энд Энержи ХХК-ийн Гүйцэтгэх Захирал Б.Амармэнд, Бодь интернэшнл ХХК-ийн ТУЗ-ийн дарга Д.Баясгалан, Пауэрчайна Ресурсэскомпанийн ТУЗ-ийн дарга Шин Юмин нар гарын үсэг зурлаа.

Дугаарын 60 мөр

Фэйсбүүк, ТВИТТЕРТ ХЯНАЛТ ХЭРЭГТЭЙ БАЙНА

Үргэлжлэл.
Түрүүч нь I нүүрт

Гэхдээ л өнөөдөр фэйсбүүк, твиттерээр бусдыг “од” болгож ч болж байна. Байж суух газаргүй болгож, амьдрал ахуйг нь уудалж, авгай хүүхний хэрүүл хийж, газар дор ортол нь ч муулж болж байгаа. Эсвэл ямар ч хамаагүй сэдэв сонгож аваад, элдвээр бичээд, бусадтай хуваалцаад, түгээгээд, шуугиан болгох жишээтэй. Хаа хамаагүй өнгөрсөн цагт болсон зүйлийг өлгөж аваад л муулах жишээтэй. Ерөнхийдөө фэйсбүүк, твиттерийг мэдээллийн хэрэгсэл гэдэг талаас нь ашиглахаа больж, бусдыг муучлах, доромжлох, худлаа шуугиан дэгдээх, хуучин муусайн юмаа зарах зах болгож л хэрэглээд байгаа юм. Дээрээс нь фэйсбүүкт өсвөр насныхан, залуус бараг л донтож, гэмт хэргийн хохирогч хүртэл болж байгааг цагдаагаас анхааруулах төдий мэдээлж байгаа. Тийм болохоор олон нийтийн цахим сүлжээг “хазаарлаж”, хяналт тавих хэрэгтэй байгаа юм. Учир нь өдөр тутмын хэрэглээ болчихоод байгаа фэйсбүүкийн сөрөг тал алхам тугамд мэдрэгдэх боллоо. Үүнээс гадна цахим орчинд үйлдэгдэж байгаа маш олон хэрэг бий. Цахим орчинд хамгийн их гарч байгаа хэргүүд гэвэл, гадаадаас Монгол Улс руу чиглэсэн цахим гэмт хэргүүд байгаа талаар албаны хүн ярьж байв. Тодруулбал, цахим шуудангийн луйвар, нигерийн залилангийн хэрэг гарч байгаа аж. Түүнчлэн Монгол Улсын дотоодод гарч байгаа хэргүүдээс дурьдвал сүүлийн үед фэйсбүүк, твиттер, сошиал ертөнцөд хүнийг гүтгэх, доромжлох буюу Эрүүгийн хуулийн 110, 111 дүгээр зүйл ангийн хэргүүд их гарч байгаа аж. Дээр нь залилангийн хэрэг, компьютер мэдээллийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг сүүлийн хоёр жилд нэлээд их гарч байгааг ч хэлсэн юм. Эрүүгийн хуулийн 110 дугаар зүйл буюу доромжлох зүйл ангид “Бусдын нэр төр, алдар хүндийг олон нийтийн өмнө доромжилсон бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 20-50 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл 1-3 сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ” хэмээн заасан байдаг. Харин 111-д “Хүний нэр төр, алдар хүндийг гутаах зорилгоор илт худал гүжирдлэг тараасан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хориос тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэгээс гурван сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ. Гүтгэлтийг олон нийтэд тараасан, эсхүл доромжлох, гүтгэх гэмт хэрэгт урьд ял шийтгүүлсэн этгээд үйлдсэн бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавин нэгээс нэг зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ” хэмээсэн байдаг. Гэвч хуурамч хаягны цаанаас үйлдэж буй энэ гэмт хэргийг тэр болгон илрүүлдэг байдаггүй. Тийм болохоор өнөөдүүл нь даварсаар даварсаар Дагвын орон гэгчээр бие биенийхээ тухай үнэн, худал мэдэгдэхгүй элдэв мэдээлэл цацаад л суугаад байна. Одоо ч байдал тийм л байна. Тэр чингээ хэрүүлтийн, гүтгэлтийн шинж чанартай бараан мэдээллүүд хөвөрсөөр л. Утга бол “Хүн нэрээ, тогос өдөө” гэдэг. Тэгэхээр хүний нэр төрд халдана гэдэг бие махбодид нь халдсанаас ч илүүтэйгээр хүнд тусдаг гэдэг шүү дээ. Ер нь ч тэгээд цахим эрх чөлөө гэдэг чинь улс орны эрх ашгаас илүү гарах учиргүй шүү дээ. Тийм болохоор фэйсбүүк, твиттерт тавих хяналтаа чангаруулмаар л байна даа.

ЦАГ ҮЕ

ДУГААРЫН СУРВАЛЖЛАГА

ЕТГ-ЫН ДАРГА П.ЦАГААН: ХАДНЫ ЗУРАГ БОЛ БҮХЭЛ БҮТЭН НОМЫН САН

Үргэлжлэл.
Түрүүч нь I нүүрт

П.Цагаан даргын хувьд Монголын түүхэн өв соёлыг хамгаалах талаар хоёр жилийн хугацаанд тасралтгүй ажиллаж, хадны зургийг бүртгэлжүүлэх, хамгаалах, улмаар нутгийн иргэдийг энэ том үйл хэрэгт идэвхи санаачилгатай оролцуулах талаар зүтгэл гаргажээ. Мөн Монголын говь, хангайд буй олон мянган хадны зураг, цогцолборыг дэлхий нийтийн анхааралд оруулах үүднээс энэхүү эрдэм шинжилгээний хурлыг зохион байгуулахаар болсон нь үр дүнгээ өгч чадлаа. Түүнчлэн, хадны зургийг хамгаалах бүртгэлжүүлэх, нэн эртний үеийн хадны зургийг тайлж унших аргачлал, хамгийн эрт үеийн хадны зураг МЭӨ хэдэн мянган жилийн өмнө бүртгэгдсэн талаар ОХУ, Франц, Испанийн эрдэмтдийн тавьсан илтгэл ях аргагүй хадны зураг судлаачдын сонирхон шимтэн сонсох илтгэлүүд байв.

“Хадны зураг бол хамгийн сонирхолтой ном юм”

Дэлхийн өв соёлын нэгэн чухал хэсэг болох хадны зургийн арвин баялаг өв сантай гурван улс дэлхийд бүртгэгдсэн байдгийн нэг нь Монгол Улс. Харин нөгөө хоёр нь Австрали, Африк юм. Мөн хамгийн эртний гэж хэлж болох 200 мянган жилийн өмнөх хадны зураг Азийн орнуудаас ихэвчлэн олддог бол 30-40 мянган жилийн харьцангуй шинэ үеийн хадны зураг Европын орнуудаас олддог гэдгийг Испанийн доктор Иполито Колладо Гирадо илтгэлдээ онцлов. Мөн 2000 жилийн өмнөх үеийн хадны зургийг шинжлэх ухааны талаас судалж, улмаар технологи ашиглах болсноор цаг хугацааны хувьд илүү тодорхой болгож чадахаар болсон байна. АНУ-ын Орегоны их сургуулийн Урлаг, уран барилгын тэнхимийн хүндэт профессор Эстер Якобсон Тефер, Вашингтон дахь Смитсоны хүрээлэнгийн Хойд туйл судлалын төвийн захирал, доктор Вильям В. Фицхью нар Хөвсгөлийн уул нурууд болон Баян-Өлгий аймгийн хадны зургийг судалж, энэ асуудалд дэлхий нийтийн анхаарлыг хандуулж чадсан хүмүүс аж. Монголын хадны зураг ихэвчлэн байгалийн ус, салхи нарны элэгдлээс гадна хүний хүчин зүйлээс хамаарч ихээхэн өөрчлөгдөж, устаж үгүй болж байгааг доктор Тефер сэтгэл эмзэглэн ярьж байлаа. Харин доктор Вильям В. Фицхью “Хадны зураг гэдэг бол бүхэл бүтэн нэг үе, монголчуудын өнгөрсөн амьдралыг өгүүлэх түүхэн ном гэж хэлж болно. Монголын буган чулуун хөшөөний зураг ихэвчлэн хүрэл зэвсгээр бүтээгдсэн байдаг. Мөн тухайн үеийн хамгийн алдартай зураачдаар зуруулсан болов уу гэх нийтлэг хэв шинж олон бий. Тухайн газар орны шүтээн болсон зүйл, мөн хэн гэж удирдагч байсан, амьдралын хэв маяг нь ямар байсан талаар хадны зургаас уншиж болно. Мөн олон улсад нийтлэг байдаг бөө мөргөлтэй холбоотой зүйл ч ажиглагддаг. Нутаг нутгийн онцлог шингэсэн гэдгийг юугаар тайлбарлах вэ гэхээр, Хөвсгөл болон Баян-Өлгий хадны зургуудад нисч буй шувуу дүрслэгдсэн байдаг. Харин Баруун Монголд байгаа хадны зурагт шувууны хэв шинж бага байх хэргэний. Буган чулууны нийтлэг хэв шинж нь дандаа удирдагчаа дурсах үүднээс зурагдсан байдаг. Миний хувьд Хөвсгөлийн уул нуруудад судалгаа хийсэн. Музейн захирал Ж.Баярсайхан бидэнд маш их тусалж байсан. Хөвсгөлийн буган чулууд Саян Алтайн бүсэд олдсон буган чулуутай тун адилхан. Тухайлбал, Мөрөнгийн хойд хэсгээс олдсон буган чулуу цаг хугацааны хувьд арай хожуу байж магадгүй. Амьтан дүрсэлсэн байдал нь маш онцлог байсан. 2800-3300 жилийн өмнөх болов уу гэж харагдаж байлаа. Мөн Мөрөнгөөс баруун урагшаа яваад олсон буган чулуу ил харахаар зүгээр л чулуу. Гэвч лавхан ухаад үзэхээр аргал, мэлхий, гахай, үхэр, өвөрмөц эвэртэй буганууд байсан. Дайчин омгийн дурсгал болов уу гэж харагдаж байлаа. Харамсалтай нь ингээд судлаад явж байхад Монголын энэ сайхан түүхэн дурсгал хүний хүчин зүйлээс шалтгаалж устаж үгүй болох асуудал тулгамдаж байгааг ажигласан. Монгол эрдэмтэд аялал жуулчлал хөгжүүлэх тухай ярьж байгаа. Гэвч эхлээд хамгаалж, хайрлах, бүртгэлжүүлэх ажлаа хийх нь чухал” хэмээн сэтгэгдлээ хуваалцлаа. Дэлхийн аль ч улс орнуудын хувьд хадны зургийг хамгаалж, хадгалах асуудал толгойлон өвчин болж байгааг ОХУ-аас ирж оролцож буй доктор Екатерина Девлет онцолж байв. ОХУ-ын хувьд хадны зургийг хамгаалах бүртгэлжүүлэх талаар төрөөс анхаарал хандуулж, улмаар тусгай төсөлжүүлжээ.



Олон улсын бага хурал таван тивийн 10 гаруй орны 100 орчим эрдэмтэн оролцдог

ЮНЕСКО-ийн соёлын өвд бүртгүүлэх талаар төр нь дэмжлэг үзүүлэн ажиллаж байгаа гэв. Оросын Шинжлэх ухааны Археологийн хүрээлэнгийн эрдэмтдээс гадна их сургуулийн эрдэмтэн судлаачид ч хадгалах, хамгаалах талаар анхаарал хандуулж ажилладаг аж. Тус улсын хадны зураг ихэвчлэн манайхтай ижил төстэй буюу хүрэл зэвсгээр урлажээ. Мөн хүний хүчин зүйл, байгалийн нар салхи усны нөлөөнөөс шалтгаалж ихээхэн өөрчлөгдсөн гэдгийг Девлет доктор хэлсэн юм. Сибирийн ой тайгад түүхэн дурсгал зөвхөн хадан дээр бус модонд ч хадгалагдаж үлдсэн байдаг ч өдгөө устаж үгүй болсон гэнэ. Харин манай өмнөд хөршийн тухайд хадны зургийг хамгаалах, бүртгэлжүүлэх талаар анхаарч ном хүртэл гаргасан байдаг юм байна.

“Хадны зурагт хамгийн гэгээлэг бүхнийг шингээж үлдээдэг”



Хөвсгөл аймгийн Уушгийн өврийн исгэрч буй эмэгтэйн хөрөг. Төслийн удирдагч П.Цагаан

Олон улсын бага хурал Монголын болон бусад улс орны хадны зураг судлал, түүхэн он цагийн хэлхээс, эрт үеийн түүхийн судалгаа шинжилгээнд туссан байдал, хадны зургийг судлах аргачлал зэрэг сонирхолтой илтгэлүүдээс гадна хадны зургийг холост дээр буулгаад өнгөөр ялгаж зурсан уран зургийн үзэсгэлэн, хадны зургийг тайлж уншсан “Хөмөргөн гурвалжин” нэртэй бүжгэн жүжгийн тоглолт, Монголын алдарт хадны дурсгалуудын нэг болох “Дэл уулын хадны зураг” үзэсгэлэн зэрэг олон үйл явдлаар хоёр өдөр үргэлжлэв. Түүнчлэн, Элчин сайд, доктор, профессор Д.Цахилгааны эмхэтгэсэн “Алтайн хадны чулуун шаштир”-ын тухай гэрэл зургийн цомог үзэгчдэд хүрлээ. Хадны зургийг өнгөнд оруулж уран зургийн үзэсгэлэнгээ гаргасан зураач Г.Тэнгисболдын хувьд өвөг дээдсийнхээ үлдээсэн хадны зургаас сэдэвлэж уран бүтээлээ туурвидаг аж. Тэрбээр, “Энэ хурлын үеэр 60 гаруй бүтээлтэй хэсэгчилсэн үзэсгэлэнгээ хүргэж байна. Цагаан сарын үеэр П.Цагаан дарга надад энэ саналыг тавьж, өдийг хүртэл баярлан хүлээж байлаа. Зургаа зурах гэж Монголынхоо бүх л газар орноор явсан. Хадны сүг зураг бол хүн төрөлхтний хүүхэд нас юм. Тухайн үеийн ард түмний хамгийн гэгээлэг зүйлсийг хаднаа мөнхлөн үлдээсэн гэж боддог” хэмээн сэтгэгдлээ хуваалцлаа. Уран бүтээлчийн энэхүү уран зургийг АСЕМ-ын үеэр хуралдаан болох гол танхимд үзэсгэлэн

...Дэлхийн дахины эрдэмтэд Африк, Австралийн хадны зураг гэж ярьдаг атлаа Монголын талаар онцолж ярьдаггүй. Тэгвэл үүнээс хойш Монголын хадны зургийг олон улсын эрдэмтдийн анхааралд оруулна гэдэг олон талаар ач холбогдолтой...

том төслийг эхлүүлж, амжилттай явуулж буй талаар төслийн удирдагч П.Цагаан болон эрдэмтдийн сэтгэгдлийг уншигч та бүхэнд хүргэе.

П.ЦАГААН: Бид хөгжлийн нэг том үүцийг хадандаа нуучихсан улс

Миний хувьд хадны зургийг хамгаалах ажилд хамгийн чухал хүмүүс нутгийн малчид, иргэд гэж боддог. Тэд соёлын өвөө хайрлаж хамгаалах талаар идэвх санаачилгатай ажиллаж эхэлж байна. С.Дулаам багш өнөө жил хадны зургийг тайлж уншаад “Хөмөргөн гурвалжин” гэх алдартай бүжгэн жүжиг бичсэн байна. Хадны зураг бол бүхэл бүтэн номын сан. Урлаг, түүх, соёл, философи, гүн ухаан бүгд багтсан. ЮНЕСКО-той хамтраад том төсөл санаачилсан нь үр дүнгээ өгч чадлаа. Дэлхийн хадны зураг судалдаг хамгийн алдартай эрдэмтэд ирлээ. Хадны зургийг “сүг” гэх мэтээр нэрлэж жийрхэх нь бий. Гэвч энэ бол бидний өвөг дээдсийн үлдээсэн гэрээс, түүхийн өв соёл юм шүү дээ. Хөгжлийн нэг том үүцийг хадандаа нуучихсан улс. Төслийг эхэлсний ач холбогдол эхнээсэс гарч эхэллээ. Эхлээд бүртгэлжүүлж, хамгаалж, хайрлах талаар ажиллаж байна. Мөн олон улсын эрдэмтэд хамтраад ажиллаж байна. Орчин үеийн шинжлэх ухаан хөгжчихсөн учраас хэдэн онд хэн гэж хүн ямар зэвсгээр бүтээснийг мэдэх боломжтой. Өнгөрсөн түүхээ хэдий чинээ мэднэ, төдий чинээ ирээдүй байдаг гэж ярьдаг. Тиймээс өнгөрсөн түүхээ судлах ажилд дэлхийн эрдэмтдийг татаж оролцуулах нь чухал юм. Дэлхийн дахины эрдэмтэд Африк, Австралийн хадны зураг гэж ярьдаг атлаа Монголын талаар онцолж ярьдаггүй. Тэгвэл үүнээс хойш Монголын хадны зургийг олон улсын эрдэмтдийн анхааралд оруулна гэдэг олон талаар ач холбогдолтой. Манай залуус гадны эрдэмтдээс суралцаж, тэр хэрээр үүх түүхээ судлах талаар илүү туршлагатай болох юм. Хадны зургийг хамгаалах ажил хэдхэн судлаачдын хийдэг ажил байгаа болж хүн бүхний анхааралд орж байгаад хувьдаа баяртай байгаа. Тухайлбал, Хөвсгөл аймагт би олон сараар явж судалгаа хийлээ. Тэнд асар олон гайхамшигтай бүтээлүүд байдаг. Монгол орны хоймор нутаг Хөвсгөл аймгийн Уушгийн өврийн исгэрч буй эмэгтэйн хөрөг бүхий гайхамшигтай буган хөшөөг энд онцлон дурьдаа. Манай хадны зургууд ихэвчлэн хонхойлгож хийсэн байдаг бол энэ зураг төвойлгож хийсэн гэдгээрээ онцлог. Мөн түүнээс холгүйхэн хоёр байсан буган хөшөө гурав болчихсон байна гэж нутгийн иргэд мэдээлсэн. Яасан бэ гэхээр, нэг нь уначихсан байхад хамгаалаггүй нөгөө хоёрыг нь хараад байсан чээ. Энэ мэтээр түүхэн соёлоо хамгаалах талаар бид учир дутагдалтай байдаг юм байна. Тэгэхээр энэ сайхан дурсгалуудаа хамгаалах, илрүүлэх талаар иргэд анхаараад эхэлсэн байна гэсэн үн. Нутгийн иргэдийг урамшуулах ёстой гэж эрдэмтэд хэлдэг. Би ч санал нэг байна. Тухайн өвийг Хөвсгөл аймгийн Алаг-Эрдэнэ сумын “Малчин Дорж”-ийн олон түүхийн өв соёл гэж бүртгэлжүүлчихмээр байгаа юм. Түүхэнд бичигдэж үлдэнэ гэдэг өөрөө асар том урамшуулал, дэмжлэг болно. Тэр хүний ач зээ, хөвсгөлдүүд

бүгд “Малчин Дорж”-оороо бахархана. Үнэхээр том нээлт хийчихвэл түүнийгээ хамгаалаад бизнес хийж болно. Хятадад байдаг газрын доорх үзмэрийг тариачин өвгөн олж нээж, улмаар тэр музейн тухай ном гаргаж, 10 ам.доллараар гарын үсэг зурж, улмаар тэрбумтан болсон түүх бий.

Д.Түмэн: Хадны зургаар хамгийн баялаг улс бол Монгол



/МУИС-ийн Археологи, антропологиийн тэнхимийн профессор/

Монгол орон бол хаданд мөнхөлсөн урлагаараа дэлхийд гайхагдах олон гайхамшигтай дурсгалуудтай. Хадны зургаар хамгийн баялаг орон бол Монгол Улс гэж би бардам хэлнэ. Хадны зураг байгальд ил учраас судлахад амархан гэж хүмүүс боддог юм шиг байгаа юм. Хиргисүүр шиг эрж хайхгүй гэх мэт. Гэвч тийм биш. Судалж тогтоох ажил байна. Хадны зурагт дүрслэгдсэн дүрслэлийг тайлж унших, тухайн үеийн хүний сэтгэлзүйн төвшинд уншиж тайлна гэдэг маш том хөдөлмөр. Сүүлийн үед хадны зургийг тайлж уншихад физикийн нарийн аргууд хэрэглэгдэж болсон байна. Монголын нутагт элбэг тохиолддог хадны зураг аль үеэр эхэлж, хэдий үеэр дуусч байгааг судлаж, энэ талаар хэлэлцэж байгаад баяртай байна. Хадны сүг зургийн дүрслэлийг тайлбарлах гэхээс илүү зохиосон эзэн, зурсан зэвсэгтэй нь, орон зай, цаг хугацааны байдлыг судлах боломж бүрдсэн. Байгаль газарзүйн тогтоц ямар байсан, ямар ан амьтан элбэг байсан, хэдийг нь гаршуулсан зэргийг хадны зургийг тайлж уншаад мэдэх боломжтой. Сүүлийн үед түүх, археологийн дурсгалыг хамгаалах, соёлын өвийг бүртгэлжүүлэх талаарх хуулийг хэрэгжүүлэх ажил эрчимжиж байна. Мөн орон нутаг сумдад соёлын өвийг хамгаалах мэргэжилтэн ажиллах болсноор бүртгэлжүүлэх, хамгаалах ажилд ахиц гарч чадлаа. Хадны зургийг иргэд хайрлах сэтгэлгүй байсан нь худлаа биш. Өөрсдийгөө мөнхөлж байна гэж нэрээ бичих асуудал их байлаа. Харин хууль хэрэгжиж, мөн энэ том төсөл хэрэгжиж эхэлснээр иргэдийн ойлголт өөрчлөгдсөн.

Д.Цахилгаан: ЮНЕСКО олон улсын төсөл болгоно гэдэгт итгэж байгаа



/“Чулуун шаштир” ТТБ-ын Дэд Ерөнхийлөгч, Монгол Улсын Онц бөгөөд Бүрэн эрхт элчин сайд/

Хадны зургийг хамгаалдаг судалдаг эрдэмтэд нэгдэж нийлээд “Чулуун шаштир” гэх төрийн бус байгууллага байгуулсан. Мөн Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга, төслийн удирдагч П.Цагаантай хамтраад олон улс руу чиглэсэн анхны том ажлыг хийж байгаа нь энэ юм. Хадны зургийг хамгаалах, судлах ажил 50 гаруй жил үргэлжилж байгаа. 1992 онд олон улсын эрдэм шинжилгээний экспедиц ажиллаж байсан. Тэрнээс хойшхи хоёр дахь том олон улсын уулзалт болж байна. Цаашлаад ЮНЕСКО энэ төслийг дэмжиж олон улсын том төсөл болгох байх гэсэн итгэлтэй ажиллана. Цуврал эрдэм шинжилгээний хурал улс дамжуулж хийх, ЮНЕСКО-ийн Ерөнхий бага хурлынх нь үеэр том үзэсгэлэн гаргах зэрэг ажил төлөвлөсөн. Өнөөдөр дөнгөж эхэлж байна гэж ойлгож болно. Хадны зургийн түүхэн өв соёлын хамгийн баян нутаг бол Монгол Улс гэдгийг эрдэмтэд хэлж байна.

УЛС ТӨР

САЙД ЯРЬЖ БАЙНА

...Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хуулийг баталснаар Монгол Улс хүүхдийн эсрэг бүх төрлийн шийтгэлийг бүх орчинд хуулиараа хориглосон дэлхийн 49 дэх, Ази тивийн гурав дахь, зүүн болон зүүн өмнөд Азийн анхны орон болсон гэдгийг энд онцлох хэрэгтэй болов уу. Эдгээр хуулиудыг боловсруулахдаа Монголчуудын уламжлалыг харгалзан “Гэр бүл төвтэй” хандлагыг баримталж хүүхдийн эрх, журамт үүргийг тодорхойлсон....



С.ЭРДЭНЭ: ХҮҮХДИЙН ЭСРЭГ ШИЙТГЭЛИЙГ ХУУЛИАРАА ХОРИГЛОСОН АЗИЙН АНХНЫ ОРОН БОЛСОН

Б.ДАВАА

Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайд С.Эрдэнэтэй хүүхэд хамгааллын өнөөгийн байдал, бодлого шийдвэрийн талаар ярилцлаа.

-Манай улс Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг 64 дэх удаагаа тэмдэглэн өнгөрүүлээ. Ер нь өнгөрсөн хугацаанд салбар яамны зүгээс хүүхдийн хөгжил, хамгааллын талаар ямар ажлуудыг хийж хэрэгжүүлэв. Энэ асуултаас хоёулаа ярилцлагаа эхлэх үү?

-Юуны өмнө айл гэрийн амин эрдэнэ, эх орны баясгалант ирээдүй хүүхэд багачууддаа Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийн мэндийг танай сонинор дамжуулан хүргэе. Жил бүрийн зургадугаар сарын 1-нд тохиодог хүүхдийн эрхийг хамгаалах өдөр, хүүхдийн баярыг дэлхий нийтээрээ ёслол төгөлдөр тэмдэглэн өнгөрүүлдэг уламжлалтай. Манай улс ч гэсэн энэ уламжлалыг дагаад 64 жил болжээ. Бидний хувьд энэ жилийн Хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг хэд хэдэн амжилттай угтаж байна. Хүүхэд, гэр бүлийн салбарт гарсан дэвшилтэй ажлууд, хууль эрх зүйн орчныг шинэчилсэн зэргийг энд хамааруулж болох байх. Энэ оны хоёрдугаар сарын 5-нд Хүүхдийн эрхийн тухай, Хүүхэд хамгааллын тухай хуулиудыг УИХ-аар хэлэлцүүлэн баталж, хүүхдийн эрхийг хангах тогтолцоог баталгаажуулсан байгаа. Энэ мэтчилэн сайхан мэдээтэйгээр хүүхдийн баяраа тэмдэглэн өнгөрүүлээ. Улсын сайн хүнээсээ, хүний сайн хүүхдээсээ гэдэг. Монгол ёс уламжлалаа мэддэг, ахас дээдсээ хүндэлдэг, хүмүүнлэг, өөрийнхөө эрхийг бусдын эрхээр хязгаарлаж чаддаг, зөвд зөөлөн, бурууд хатуу, байгаль эх дэлхийгээ хайрлан хамгаалдаг зөв монгол хүн байхын тулд хүүхэд бүр өөрийн гэсэн хүсэл тэмүүлэлтэй, түүндээ хүрэх чин зорилготой, зорилго бүр нь амжилттай гэрэл гэгээ дүүрэн байх учиртай. Хүүхдийн хөгжлийн анхдагч орчин нь гэр бүл учраас хүүхдийг зөв хүмүүжүүлэх, хөгжүүлэх, тэднийг ирээдүйд сайн хүн болгон төлөвшүүлэхэд гэр бүлийн халуун, дулаан уур амьсгал, аав, ээжийн хайр энэрэл, үнэт сургааль, үүрэг хариуцлага хамгаас чухал. Төр, засгийн зүгээс ч хүүхэд, өсвөр үеийнхний хөгжил, хамгааллын асуудлыг гэр бүлд суурилсан хөгжлийн бодлогын хүрээнд цогцоор нь авч үзсэн. Бид хүүхдийн өмнө учирч буй аливаа эрсдлийг бууруулах, хүүхдэд ээлтэй, аюулгүй орчин нөхцлийг бүрдүүлэх асуудалд нийгмийн анхаарлыг хандуулж, хүүхэд, өсвөр үеийнхний дуу хоолойг сонсох, шийдвэр гаргах төвшинд тэдний оролцоог хангах зорилгоор “Бид оролцъё, хөгжъё” хүүхдийн үндэсний

чуулганыг Монголын Хүүхдийн ордонд хоёр удаа амжилттай зохион байгуулж, “Хүүхдийн эрх, хамгааллын асуудлаар үүрэг хүлээгчдийн харуцлага” улсын зөвлөгөөнийг Төрийн ордонд зохион байгуулж, шинээр батлагдсан хуулиудад тусгаж чадсан.

-Хүүхдийн эрх гэр бүлийн орчинд ихэнхдээ зөрчигддөг гэдгийг салбарын мэргэжилтнүүд хэлдэг юм билээ. Хүүхдэд чиглэгдсэн дээрх хуулиуд батлагдан, хэрэгжиж эхэлснээр ямар дэвшилт гарна гэж таны хувьд харж байна вэ?

-Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хуулийг баталснаар Монгол Улс хүүхдийн эсрэг бүх төрлийн шийтгэлийг бүх орчинд хуулиараа хориглосон дэлхийн 49 дэх, Ази тивийн гурав дахь, зүүн болон зүүн өмнөд Азийн анхны орон болсон гэдгийг энд онцлох хэрэгтэй болов уу. Эдгээр хуулиудыг боловсруулахдаа Монголчуудын уламжлалыг харгалзан “Гэр бүл төвтэй” хандлагыг баримталж хүүхдийн эрх, журамт үүргийг тодорхойлсон. Мөн уг хуулиуд нь хүүхдийн эрхийг хангахад төрийн байгууллага, иргэн, аж ахуйн нэгж байгууллагын эрх, үүргийг тодорхойлж өгснөөрөө онцлогтой. Хууль батлагдсанаар олон асуудал шийдлээ олж чадсан. Тухайлбал, хуулиар тухайн орон нутгийн Засаг дарга нар төрийг төлөөлж хүүхдийн эрхийг хангах, хамгаалах, хяналт тавих үүргийг өөрийн нутаг дэвсгэртээ хэрэгжүүлнэ. Нутгийн өөрөө удирдах байгууллага орон нутгийн хэмжээнд хүүхдийн зөрчигдсэн эрхийг сэргээх үйл ажиллагаанд шаардагдах төсвийг баталж байхаар зохицуулагдсан. Үүнээс гадна хүүхдийн эрх зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлага ч сайжирлаа. Хүүхдийн эсрэг хүчирхийлэл үйлдсэн, эрхийг зөрчсөн тохиолдолд Эрүүгийн болон Зөрчлийн тухай хуулиудаар хариуцлага тооцуулах зарчим үйлчилнэ. Мөн хууль зөрчсөн болон гэмт хэргийн гэрч, хохирогч хүүхдэд Хүүхдийн эрхийн хууль зүйн хороо туслахаар болсон байгаа. Ер нь хүүхэд хамгааллын үйлчилгээг олон улсын жишигт нийцүүлэн хөгжүүлэх эрх зүйн орчин бүрдсэн гэж ойлгож болно.

-Өмнө гэр бүлийн орчинд үйлдэгддэг хүчирхийлэлд хорооны ажилчид нөхцөл байдлын үнэлгээ хийх ёстой байсан. Энэ асуудлыг шинэ хуулиар хэрхэн зохицуулж өгсөн бэ?

-Сум, хорооны төвшинд эрх нь зөрчигдсэн хүүхдийн талаар нөхцөл байдлын үнэлгээ хийж, цаашид тухайн хүүхдэд шаардлагатай үйлчилгээний талаар дүгнэлт, зөвлөмж гаргах, яаралтай тусламж, үйлчилгээ үзүүлэх, зөвлөгөө өгөх чиг үүрэг бүхий хамтарсан баг ажиллана. Хамтарсан багийг хүүхэд, гэр бүлийн хөгжлийн

ажилтан, өрхийн эмч, цагдаагийн ажилтны бүрэлдэхүүнтэйгээр сум, хорооны Засаг даргын захирамжаар байгуулан ажиллах ёстой байгаа.

-Хэвлэл мэдээлэл, цахим орчинд хүүхдийн эрх их зөрчигдөж буй асуудал сүүлийн үед хурцаар тавигдаж байгаа. Энэ тухайд?

-Хүүхэд хамгааллын тухай хуульд боловсрол, эрүүл мэнд, хэвлэл мэдээлэл, цахим орчинд худалдаа үйлчилгээ, олон нийтийн газар дахь хүүхэд хамгааллын асуудлыг тусгаж, эрх зүйн зохицуулалт хийгдсэн. Жишээлбэл, хэвлэл мэдээлэл, цахим орчин дахь хүүхэд хамгааллын урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажлыг Харилцаа холбооны зохицуулах хороо, Цагдаагийн ерөнхий газар тогтмол зохион байгуулах, багш сурган хүмүүжүүлэгч, эцэг эхчүүд цахим орчны сөрөг нөлөөлөөс хүүхдийг хамгаалах, зөв мэдээлэл өгөх, урьдчилан сэргийлэх асуудлыг оруулж өгсөн байгаа.

-Хүүхдийн эрхийн улсын байцаагчтай болсон гэлээ. Хэдэн байцаагч ямар зарчмаар ажиллах юм бэ?

-Эхний удаа аймаг, дүүрэг бүрт нэг улсын байцаагч ажиллана. Цаашид хэрэгцээ шаардлага гарвал тоог нь нэмэгдүүлнэ. Байцаагч нар хүүхдийн эрхийн чиглэлээр таваас доошгүй жил ажилласан, тодорхой туршлага хуримтлуулж мэргэшсэн хүмүүсээ сонгон шалгаруулна. Сонгон шалгаруулалтад тэнцсэн хүмүүсээ дахин

сургалтад суулгаад улсын байцаагчийн эрх олгох юм.

-Шүүхэд гэмт хэрэг үйлдсэн хүүхдийг мэргэшсэн шүүгч шүүнэ гэсэн эрх зүйн зохицуулалт орсон байсан. Үүнийг хэрхэн зохицуулахаар болсон бэ. Сая шүүх байгуулах тухай хууль батлагдсан шүү дээ?

-Хүүхдийн эрхийн гол хуулиуд есдүгээр сарын 1-нээс эхэлж хэрэгжиж эхэлнэ. Мөн хүн амын бүлгүүдийн эрхийн тухай асуудал туйлын чухал байгаа. Тухайлбал, хүний эрхийн тухай асуудлыг ярихдаа залуу хүний эрх гэдэг зүйлийг огт ярьдаггүй. Ямар нэг ажилд орохгэхээр өндөр, нам, тарган, туранхай, царай муутай гээд ялгаварладаг байх жишээтэй. Хуульд заасны дагуу ямар үндэслэлээр тухайн иргэнийг ажилд авахгүй вэ гэдгээ тайлбарласан тайланг тухайн байгууллага өгөх ёстой. Харин тайлангаа өгөөгүй тохиолдолд тэр залуу гомдол гаргах эрхтэй. Энэ мэтчилэн эрхийн тухай хуулиуд их чухал байна. Мөн хүүхдийн эрхийн асуудлууд ч байна. Хүүхдийн хүчирхийлэл явагдаж байна гэдгийг мэддэг хэрнээ ороод таслан зогсоож чаддаггүй. Хүмүүс харсан хэрнээ хараагүй юм шиг л өнгөрдөг. Ер нь хүүхдээ хүчирхийлсэн эцэг эхийн эцэг эх байх эрхийг нь хасах хүртэл арга хэмжээ авах хэрэгтэй шүү дээ. Монгол Улсын хүн амын 37.2 хувийг 0-18 насныхан эзэлдэг. Энэ насны хүүхэд, залуу үеийнхний аж байдал, тэдний хөгжих, хамгаалуулах

эрхийг хангахад чиглэсэн хүүхдийн хөгжил, хамгааллын асуудал нийт хүн амын хөгжлийн талаарх бодлогын төвд байх ёстой хамгийн чухал асуудлыг нэг юм. Тиймдээ ч, бид өнгөрсөн дөрвөн жилд хүүхдийн хөгжил, хамгааллын чиглэлээр тулгамдаж байгаа асуудлуудыг тодорхойлох зорилгоор 20 гаруй судалгаа, хэд хэдэн удаагийн чуулган хэлэлцүүлгийг хийж, тэдгээрээс гарсан санал, зөвлөмж шийдвэрүүдийг төрийн бодлого, хууль тогтоомжийг боловсруулахад тусгаж ирлээ.

-Олон нийтийн дунд удаан хугацаанд хүлээлт үүсгэсэн Хүүхэд харах үйлчилгээний тухай хууль саяхнаас хэрэгжиж эхэлсэн. Үр дүн нь хэр байна?

-Хүүхэд харах үйлчилгээнд энэ онд нийт 10300 орчим хүүхэд хамрагдана. СӨБ-д хамрагдаж чадахгүй байгаа 2-6 насны хүүхэд эрүүл аюулгүй, хамгаалагдсан орчинд өсч торних, хөгжих, хүмүүжих боломж бүрдлээ шүү дээ. Үүнээс гадна 11000-12000 иргэн байнгын шинэ ажлын байртай болох боломжтой боллоо. Хүүхэд харах хүнгүйн улмаас хөдөлмөр эрхэлж чадахгүй байгаа эцэг эх, асран хамгаалагч ажил хийж, орлогоо нэмэгдүүлэх боломжтой болж байгаа юм. Эдгээр хуулиудын хэрэгжилтийг хангах бэлтгэл ажлын хүрээнд хуулийг дагаж гарах үндэсний хөтөлбөр, дүрэм, журам, стандартуудыг боловсруулж байна.

МОНГОЛЫН МЭДЭЭ

18дэх жилээ

СОНИН

ЦААСААР Ч, ЦАХИМААР Ч

УНШДАГ БОЛЛОО



“Монголын мэдээ” сонины цахим хувилбарыг mminfo.mn сайтаас үнэгүй уншаарай

ДЭЛХИЙ

ДЭЛХИЙН УДИРДАГЧДЫН

ХҮҮХЭД НАС

Б.ДАВААХҮҮ

Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдөр өчигдөр тохиолоо. Бидний нэрлэж заншсанаар хүүхдийн баярыг манай улс 64 дэх жилдээ бүх нийтээрээ тэмдэглэн өнгөрүүлэв. Бяцхан үрсийн хүсэн хүлээдэг баяр болох энэ өдрийг анх 1925 оноос дэлхий нийтээрээ тэмдэглэж ирсэн түүхтэй билээ. Өчигдрийг гэр бүл бүхэн чадах чинээгээрээ үр хүүхдээ баярлуулсан өнгөрүүлсэн лавтай биз ээ. Тэгвэл бид энэ удаа Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдөртэй холбогдуулан дэлхийн хүчирхэг удирдагчдын хүүхэд насны талаарх мэдээ мэдээллийг бэлтгэлээ. Эдүгээ олон улсын бодлогыг тодорхойлж буй эл эрхмүүд хүүхэд насандаа ямар амьдралыг туулж, яаж амжилтад хүрч байсныг уншигчиддаа сонирхуулж байна.

1. Барак Обама



АНУ-ын 44 дэх Ерөнхийлөгч Барак Хуссейн Обама эдүгээ дэлхийн хүчирхэг удирдагчдын нэг. Гэхдээ түүний бага нас гэр бүл салалт, хойд эцгийн хараа хяналт, эмээ, өвөөгийн хайр халамж дунд өнгөрчээ. Тэрбээр 1961 оны наймдугаар сарын 4-ний өдөр Хавайд төрсөн байна. Түүний эх Анн Дунхам, эцэг Барак Обама нар Хавайн их сургуульд 1960 онд танилцаж, үүнээс нэг жилийн дараа тэд гэр бүл болж бяцхан Обама хорвоод мэндэлж байв. Анн Дунхам Кансасаас ирсэн цагаан арьст оюутан бүсгүй байсан бол эцэг нь Кэниас дээд боловсрол эзэмшихээр ирсэн өнгөт арьст залуу байжээ. Хүүгээ төрсний дараа нэг жилийн хугацаанд Анн Дунхам Сийтлийн Вашингтоны их сургуульд суралцсан байна. Харин энэ хооронд эцэг нь сургуулиа төгсч, Харвардын их сургуульд үргэлжлүүлэн сурахар болсон байдаг. Эцэг нь гэр бүлээ орхин явах үед бяцхан Обама ердөө хоёрхон настай байсан бөгөөд төд удалгүй эцэг эх нь тус тусын амьдралаа хөөх болсон байна. Хоёрхон настайдаа гэр бүл салалтын хохирогч болж үлдсэн бяцхан Обама түүнээс хойш 1971 онд ердөө ганц л удаа төрсөн эцгийнхээ царайг харж байсан гэдэг. Анхны гэрлэлт нь бүтэлгүйтсэн Анн Дунхам Индонезоос гаралтай Лоло Соёгоро гэгчтэй хоёр дахиа гэрлэсэн байна. Ингээд 6-10 нас хүртлээ Обама хойд эцгийн царай харж, Индонезид амьдарч байсан бөгөөд энэ хугацаанд католик болоод мусальман шашны сургуульд явдаг байжээ. Тэр үеэ “Би индонез хүүхэд ч юм шиг, Хавайн хүүхэд ч юм шиг бас хар ч юм шиг цагаан арьстай ч юм шиг өссөн” хэмээн онцолсон удаатай. Харин дараа нь тэрбээр өвөө эмээгийнхээ гар дээр ирж, тэндээ ахлах сургуулиа төгссөн байна. Обамаг дунд сургуульд байх үед ээж нь нөхрөөсөө салжээ. Барак Обамагийн бага насны амьдрал төгс биш, их сургуульдаа тийм ч сайн оюутан байгаагүй ч, тэрбээр Нобелийн энх тайвны шагналыг хүртэж, АНУ-ын анхны хар арьст Ерөнхийлөгч болсон хүчирхэг удирдагч билээ.

2. Владимир Путин



Владимир Владимирович Путин 1952 оны аравдугаар сарын 7-нд Ленинград хотод төржээ. Түүний ээж Мария Ивановна Путина үйлдвэрийн ажилчин, харин эцэг Владимир Спиридонович Путин 1930 оны үед шумбагч онгоцны усан цэрэг байсан бөгөөд дэлхийн II дайн үед тэр НКВД-ийн тагнуулын хорлон сүйтгэх тасагт ажиллаж байсан гэдэг. В.Путин хоёр ахтай байсан хэдий ч хоёулаа бага насандаа өөд болжээ. Ленинградын бүслэлтийн дараах жилүүдэд гэр бүлийнх нь амьдрал туйлын хүнд хэцүү байсан бөгөөд нийтийн байранд амьдарч байсан гэдэг. Тэнд В.Путин бүх л цагаа хонгилд харх хөөж өнгөрүүлдэг байжээ. Халуун ус, 00-ын өрөө, ванн ч үгүй нийтийн байрны таван давхрын 200 фут квадрат талбайтай давчуу өрөөнд В.Путины бага нас өнгөрчээ. В.Путин багадаа үнэхээр дэггүй хүүхэд байсан гэдэг. Ангийн нөхөд нь ч түүнийг сахилгагүй байсан хэмээн дүгнэдэг байна. 12 наснаасаа эхлэн тэрбээр бокс, каратэ, самбо, жудо, тулааны урлагаар хичээллэх болжээ. Спорт түүнд анхаарлаа төвлөрүүлэх чадамжийг олгосон төдийгүй дутуугаа дүүргэхэд нь тусалжээ. Тэрбээр багаасаа л тагнуулч болох хүсэл мөрөөдөлтэй байсан тул хуулийн сургуульд суралцан Улсыг Аюулаас Хамгаалах Хороонд ажиллах түлхүүрээ атгаж байсан байна. Энэ сонголт нь түүний амьдралыг орвонгоор нь эргүүлжээ. В.Путин 1970 онд Ленинградын их сургуульд элсэн орж, таван жилийн дараа хуульч мэргэжлийн цол тэмдгээ авсан байна.

3. Ангела Меркель



Ангела Доротеа Каснер 1954 оны долдугаар сард Хамбург хотноо шашин судлаач, номлогч Хорст Каснер, Херлинд Каснер нарын гурван хүүхэдтэй айлын ууган охин болон мэндэлжээ. Тэрбээр эрэгтэй, эмэгтэй хоёр дүүтэй аж. Эцэг нь номлогч, эх нь багш тэднийг Социал Демократ намын цор ганц гишүүн байсан болохоор ч тэр үү Меркель шашин, төрийн баг наснаасаа л сонирхож эхэлсэн гэдэг. Мөн тэрбээр залуудаа математик, шинжлэх ухааны хичээлдээ сайн байсан бөгөөд гадаад хэлийг ч сонирхон судалдаг байжээ. 1968 онд Ангела 14 настай байхдаа Ардчилсан Герман Улсад орос хэлний олимпиадад нэгдүгээр байр эзлэн ЗХУ-д аялах эрхээр хүртэл шагнуулж байсан удаатай аж. Герман төмөр хөшгөөр зааглагдан хоёр хуваагдсан тэр үед зүүн германчууд төмөр хөшгийг нэвтлэн баруун руу гарахыг хүсдэг байсан ч, Меркеллийн эцэг харин эсрэгээр зүүн Германд ажиллахаар нүүж байв. 1973 онд Меркель Лейпцигийн их сургуульд физикч мэргэжлээр элсч, 1978 онд онд сургуулиа дүүргэжээ. Мөн химийн квантын чиглэлээр докторын зэрэг хамгаалсан нэлээд чадварлаг, физикч, химич нэгэн. Тэрбээр сургуулиа төгссөнийхөө дараа 1989 онд Берлиний хана нурж, хоёр Герман нэгдэх хүртэл Ардчилсан Германы шинжлэх ухааны академид мэргэжлээрээ ажиллаж байгаад, 1990 оноос улс төрд оржээ.

4. Си Зиньпин



БНХАУ-ын хамгийн хүчирхэг удирдагчдын нэгд зүй ёсоор тооцогддог Си Зиньпиний хүүхэд насны он жилүүд тийм ч сайн сайхан байгаагүй гэдэг. Тэрбээр 1949 оны Хятадын коммунист хөдөлгөөний удирдагч Си Жонсуны хүү. Энэ ч утгаараа улс төрийн шинжтэй баривчилгаа тэдний гэр бүлийг тойроогүй. 1962 онд эцэг Си өөрийн хашиж байсан албан тушаалаасаа бууж, хол газар үйлдвэрт ажиллаж эхэлсэн байна. Харин 1968 оны соёлын хувьсгалын үеэр шоронд хоригджээ. Тухайн үед Си Зиньпин 15 настай байдаг бүүж. Эцгээс нь салгасан жилүүд түүний амьдралын хамгийн хүнд үе байсан хэмээн хожмоо дурссан байдаг. Гэхдээ энэ бүхэн түүнийг хал үзүүлж, амьдралд төвчээртэй, асуудлыг шийдэж чадах чадварт сургасан байна. Си дарга 1969 онд эцгийгээ хамгаалахын тулд Шааньси мужийн Лианжиах гэх хөдөөгийн жижиг тосгон руу нүүж, ажиллах болжээ. Тухайн үед амьдарч байсан гэрээ тэрбээр агуйтай адилтгасан байдаг. Агуй шиг оромжинд амьдарч худгаас ус татан цагаан будаа тариалдаг байсан аж. Энэ үеэс л Си ажилч хичээнгүйгээрээ орон нутгийн хүмүүсийн сайшаал магтаалыг хүртэх болж, улмаар улс төрийн карьераа 1971 онд Коммунист залуучуудын холбоонд элсч эхлүүлсэн байдаг. Чухам энэ мөчөөс эхлэн Си Зиньпин залуучуудын улс төрийн үйл ажиллагаанд идэвхтэй оролцож, Хятадын олон муж улсад албан тушаал дэвшин ажилласан байна. Хэдийгээр 1975-1979 онд Си Зиньпин химийн инженерийн мэргэжлээр Цинхуагийн Их сургуульд сурч төгссөн ч, сургалт судалгааны чиглэлээр ажиллахыг хүсээгүй гэдэг.

5. Ким Жон Ун



Эцэг Ким Чен Иррийг нас барсны дараа улс орноо удирдах болсон Ким Жон Ун дэлхийн хамгийн залуу удирдагч, басхүү харгис дарангуйлагч гэгддэг. Түүний төрсөн он ч тодорхойгүй. Бусад ах, эгч нарынхаа адил Швейцарьт боловсрол эзэмшсэн түүний багын зураг ч бараг байдаггүй гэдэг. Швейцарьт хувийн сургуульд боловсрол эзэмшихдээ Ким Жон Ун Хойд Солонгосын элчин сайдын яамны ажилчны хүү “Пак Ун” гэх нэрээр Берний хотын Гумлигенийн англи хэлтэй олон улсын сургуульд бүртгүүлжээ. Ангийнхан нь Жон Уныг ихэнх цагаа байрандаа өнгөрөөдөг, дуу цөөтэй оюутан байсан гэжээ. Мөн хошигнох мэдрэмжтэй нэгэн байсан гэдэг. Харин багынх нь зан араншинг гэрт нь тогоочоор ажиллаж байсан Кэнжи Фужимори гэгч л дурсч байсан удаатай. Долоон насандаа машин жолоодож, 14 насандаа согтууруулах ундаа хэрэглэж явсан бяцхан Ким юм бүрийг туршиж үзэх хүсэл эрмэлзэлтэй байжээ. Кэнжи “Би тэднийд хоёр ажил хийж байсан. Нэг нь Ким Чен Иррийн сушины тогооч, мөн хүүхдүүдтэй нь тоглодог асрагч байлаа” хэмээсэн удаатай. Тиймдээ ч Ким Жон Уны талаарх тодорхой зүйлийг олон нийтэд дэлгэх цор ганц хүн юм. Зургаан наснаасаа хойш Ким Жон Ун тогоочтойгоо бүх л өдрийг хамт өнгөрүүлдэг байжээ. Хүүхэд насандаа сайн гэхээсээ илүү саар зүйлд шимтэж байсан гэх мэдээлэл байгаа ч, тэр эдүгээ дэлхийн хамгийн хаалттай, ганцаардмал улсыг толгойлж байна.

Улаанбаатарт - 08 сарын 17

20°

minfo.mn

Шударга, Шуурхай, Онигой мэдээлэл

Эхлэл | Улс төр | Эдийн засаг | Нийгэм | Дэлхи

Вайлт хийх

Катерон Дуас: Тэрлэлт миний хувьд гэнэтийн бэлэг байсан

Дэлгэрэнгүй мэдээллийг MMINFO.MN сайтаас

ШУУРХАЙ МЭДЭЭ

ХӨДӨЛМӨРИЙН ЧАДВАР ТҮР АЛДАЛТЫН ТЭТГЭМЖИЙГ 132 ӨДРӨӨР ТООЦОЖ ОЛГОДОГ

-Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмжийн талаар тайлбарлаж өгөхгүй юу. Хэдий хугацаанд олгодог юм бэ?

-Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль бий. Энэ хуулийн 17 дугаар зүйлд ердийн өвчин, ахуйн ослын улмаас хөдөлмөрийн чадвараа түр хугацаагаар алдахаас өмнө гурав, түүнээс дээш сарын хугацаагаар тэтгэмжийн даатгалын шимтгэл төлж ажилласан даатгуулагч хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж авах эрхтэй гэж заасан байдаг. Гэхдээ ажилласан жил, нийгмийн даатгал төлсөн хугацаанаас хамаарч харилцан адилгүй л дээ. Жишээлбэл, тасралтгүй таван жил ажиллаж, шимтгэл төлсөн бол 50 хувиар, 5-14 жил ажилласан бол 55 хувиар боддог. Харин 15-аас дээш жил ажиллаж, нийгмийн даатгалын шимтгэлээ тасралтгүй төлсөн байвал 75 хувиар тооцож боддог. Бодохдоо ажлын өдрөөр тооцно.

-Хөдөлмөрийн чадвараа түр алдсаны тэтгэмжийг хэдий хугацаанд олгох ёстой байдаг юм бэ. Хуулиараа хэрхэн зохицуулдаг бол?

-Тухайн хүн хөдөлмөрийн чадвараа алдсан хугацаанаас эхэлж тооцон ажлын эхний тав хоногийн тэтгэмжийг ажил олгогч олгодог. Зургаа дахь өдрөөс эхлэн чадвар нь сэргээгдэх эсвэл тахир

Н.БАТЗАЯА

Хөдөлмөрийн чадвараа түр алдсаны тэтгэмж, жирэмсний болон амаржсаны тэтгэмжтэй холбоотой асуудлаар Сүхбаатар дүүргийн нийгмийн даатгалын газрын тэтгэмжийн мэргэжилтэн М.Отгонбаяраас тодрууллаа.

дутуугийн тэтгэвэр авах эрх үүсэх хүртэл хугацааны тэтгэмжийг даатгалын сангаас олгох ёстой гэж холбогдох хуульд заадаг. Тэтгэмж олгох хугацааны нэг удаагийн дээд хязгаар нь 66 өдрөөс хэтрэх ёсгүй. Гэхдээ 66 өдөртөө хөдөлмөрийн чадвар алдсан ажлын эхний таван өдрийг оруулдаг. Хоног нэмж олгогдох тохиолдол байна л даа. Энэ нь хорт хавдар болон сүрьеэгээр анх өвчлөхөд ажлын 132 өдрөөр тооцож тэтгэмж олгодог.

-Хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэмжийг дахин авч болдог уу?

-Болно. Гэвч тодорхой нөхцөл бий. Даатгуулагч хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж авч дууссаны дараа тэтгэмжийн даатгалын санд гурван сараас доошгүй хугацаагаар шимтгэл төлсөн нөхцөлд дахин тэтгэмж авах эрх нь үүсдэг.

-Жирэмсэн болон

амаржсан эхийн тэтгэмж авах эрх хэрхэн үүсдэг юм бэ?

-Жирэмсэн болон амаржсаны тэтгэмжийг мөн нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулиар зохицуулдаг. Хуульд тэтгэмжийн даатгалын шимтгэлийг жирэмсний чөлөө авахаас өмнө 12 сараас доошгүй хугацаанд, үүнээс сүүлийн зургаан сард нь уг шимтгэлийг тасралтгүй төлсөн даатгуулагч авах эрхтэй гэж заадаг. Мөн дутуу төрөх, үр хөндүүлэх, жирэмслэлтийг эмнэлгийн аргаар таслах тохиолдлууд байдаг. Ийм тохиолдолд тэтгэмж авч болох уу гэж хүмүүс асуудаг. Энэ асуудлыг хууль эрх зүйн хүрээнд зохицуулсан. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 19 дүгээр зүйлд 196 хоног тээсэн бол жирэмсний болон амаржсаны тэтгэмж авах эрхтэй гэсэн

байгаа. Мөн хэдийгээр 196 хоног тээгээгүй ч гэсэн амьдрах чадвартай хүүхэд төрүүлсэн л бол жирэмсний болон амаржсаны тэтгэмж авна.

-Жирэмсний болон амаржсан эхийн тэтгэмжийг хэрхэн бодож олгох уу?

-Даатгалын төрлөөс хамаарч олгох хувь нь өөр л дөө. Жишээлбэл, хуульдаа тэтгэмжийн даатгалд даатгуулж шимтгэл төлсөн хөдөлмөрийн гэрээгээр ажилладаг болон төрийн албан хаагч эхэд жирэмсний болон амаржсаны тэтгэмжийг тэтгэмжийн даатгалын шимтгэл төлсөн сүүлийн 12 сарын хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогын дунджаас 100 хувиар тооцож дөрвөн сарын хугацаанд олгоно гэж заадаг. Харин сайн дураар тэтгэмжийн даатгалд даатгуулсан эхэд жирэмсний болон амаржсаны тэтгэмжийг тэтгэмжийн даатгалын шимтгэл төлсөн сүүлийн 12 сарын хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогын дунджаас 70 хувиар тооцож сарын хугацаанд нийгмийн даатгалын сангаас олгоно. Ер нь тооцох хувь нь өөр гэсэн үг. Ажил хөдөлмөр эрхэлдэг бол 100 хувиар бодно. Харин сайн дураар даатгуулсан бол 70 хувиар бодох юм.

-Жирэмсний болон амаржсаны тэтгэмжтэй байх хугацаанд нийгмийн даатгалын шимтгэл

төлөгдөх үү?

-Нийгмийн даатгалын шимтгэл төлөгдөнө. Уг тэтгэмжийг авсан байх хугацаанд аж ахуй нэгж байгууллага нь төлдөг. Үүнд Засгийн газраас тогтоосон хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ гэж байгаа. Тэр хэмжээнээс ажил олгогчийн төлбөл зохих хувиар сар бүр төлөх юм. Нэг үгээр бол ажил олгогчид төлдөг гэсэн үг.

-Тэтгэмж авахын тулд ямар материал бүрдүүлэх ёстой вэ?

-Харьяа дүүргийнхээ нийгмийн даатгалын газарт эмнэлгийн хуудас, нийгмийн даатгалын дэвтэр, иргэний үнэмлэхтэйгээ очиход болно.

-Төрөхийн өмнөх эмнэлгийн хуудсыг хэзээ бичих вэ. Бичсэнээсээ хойш хэд хоногийн дотор нийгмийн даатгалын газарт очих шаардлагатай вэ?

-Даатгуулагчид эмнэлгийн байгууллагаас жирэмсний болон амаржсаны хуудсыг жирэмсний амралт эхэлснээс хойш 30 хоногийн дотор, амаржсаны дараа 30 хоногийн дотор олгодог юм. Тухайн даатгуулагч эмнэлгийн хуудсыг хүний нөөцийн ажилтандаа аваачиж өгөх ёстой. Харин ажил олгогч эмнэлгийн хуудас бичигдсэнээс хойш 28 хоногийн дотор нийгмийн даатгалын байгууллагатай тэтгэмжийн тооцоо хийх

Иргэдэд нөхөн олговор өгөх журам батлагдвал

Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Э.Бат-Үүл "Нөхөх олговрын хөрөнгө гаргах тухай" А/421 дүгээр захирамж гаргалаа. Захирамжаар Нийслэлийн Засаг даргын дэргэдэх "Гудамж" төслийн хөрөнгөөр хийж байгаа Хан-Уул дүүргийн гуравдугаар хороо Эрчим хүчний гудамжийг Ажилчны гудамжтай холбох 0.7 км авто замын ажлын трасст өмчлөлийн газар нь орсон иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын үл хөдлөх эд хөрөнгийн нөхөх олговрын хэмжээг батлав. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын үл хөдлөх эд хөрөнгийн нөхөх олговор болох 434 сая 300 мянган төгрөгийн нийслэлийн 2016 оны төсөвт батлагдсан нөхөх олговрын хөрөнгөөс гаргахыг нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэст даалгалаа. Иргэний өмчилсөн газрын нөхөх олговрын гэрээг холбогдох хууль тогтоомжийн дагуу байгуулж гэрээнд заасан хугацаанд газар чөлөөлөхийг нийслэлийн Өмчийн харилцааны газарт, захирмжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг нийслэлийн Засаг даргын Зам тээвэр, дэд бүтцийн асуудал хариуцсан орлогч Н.Гантөмөрт үүрэг болголоо.

Баянчандманьд малын эмч бүсгүйг хүчирхийлсэн этгээдийг шүүх хурал хойшлов

Баянчандмань сумын Засаг даргын тамгын газарт малын эмч хийдэг Б гэх 26 настай бүсгүйг хуралд сууж байх үед нь Засаг даргын орлогч Б.Ханбаатар, Тамгын газрын дарга Г.Ариунболд нар малын гоц халдварт өвчин гарсан гэх нэрийдлээр бүсгүйг худлаа хэлж айлын унага тамганы найранд аваачсан улмаар хүчирхийлсэн хэрэг өнгөрөгч оны есдүгээр сард гарч нийгмийг цочроогоод байсан билээ. Хохирогч бүсгүй ганц бие нэгэн байсан бөгөөд архи уусан үедээ дур хүслээ зүй бусаар хангасан гэх хэргээр Б.Ханбаатар шалгуулж, харин Г.Ариунболдыг хэрэгт хамааралгүй хэмээн сулласан. Энэ хэрэгт буруутгагдаж байгаа Б.Ханбаатарын үйлдэлд Эрүүгийн хуулийн тусгай ангийн 96 дугаар

зүйлийн 96.2.1, 96.2.6, 96.2.8, 96.2.9, 125 дугаар зүйлийн 125.2, 126 дугаар зүйлийн 126.2.1, 126.2.5, 181 дүгээр зүйлийн 181.2.1 дахь хэсэгт зааснаар ялгах дүгнэлт үйлдэж шүүхэд ирүүлсэн билээ. Уг хэргийн мөрдөн байцаалтын ажиллагаа дууссан бөгөөд шүүх хурал нь тавдугаар сарын 30 -д Баянгол, Хан-Уул, Сонгионхайрхан дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхэд эхэлсэн ч прокурор гадаад улсад томилолттой байгаа тул хэргийг энэ сарын 15-ны өдөр хүртэл хойшлуулсан байна. Улмаар хохирогч бүсгүй олон удаагийн хагалгаанд орж биений байдал нь бага зэрэг сайжирсан ч сэтгэл санааны хувьд сайжраагүй гэдгийг хохирогчийн ар гэрийнхэн хэлж байгаа билээ.

24 орон сууцны 54 орцыг камержуулжээ

Хөршийн хяналтын хөтөлбөр"-ийг өнгөрөгч нэгдүгээр сараас хэрэгжүүлж эхэлсэн билээ. Энэ хүрээнд орон сууцны иргэд хоорондоо танилцаж, нэгдэн "Хөршийн хяналтын бүлэг" байгуулж, байраа тохижуулах, аюулгүй байдлыг хангахаар ажиллаж эхэлсэн нь үр дүнд хүрч эхэлжээ. Одоогоор 815 бүлэг байгуулагдаад байгаа бөгөөд хөршүүдэд зориулсан www.neighbourhood.mn цахим хуудсанд 1800 гаруй иргэн бүртгүүлээд байгаа гэнэ. Тухайлбал, Чингэлтэй дүүргийн тавдугаар хорооны иргэд "Хөршийн хяналтын бүлэг" байгуулж, 24 орон сууцны 54 орцыг камержуулжээ. Ингэснээр ахуйн хүрээний гэмт хэргийн гаралт буурсан байна. Мөн Хан-Уул дүүргийн зургаа, долдугаар хорооныхон ч орчноо бүрэн камержуулжээ. Гол нь орчноо камержуулж,

"Камерын хяналтын бүс" гэсэн тэмдэглэгээг гудамжинд байрлуулах нь гэмт хэрэг гарахаас сэргийлэх томоохон алхам гэдгийг цагдаагийн байгууллагаас анхааруулж буй. Түүнчлэн "Хөршийн хяналтын хөтөлбөр"-ийн "Ipolice" буюу "Би цагдаа" гэх нэртэй гар утасны аппликейшныг хэрэглээнд нэвтрүүлж эхэлсэн байна. Тиймээс иргэд гар утасныхаа Playstore-ноос Ipolice аппликейшныг гар утсанд суулгаж болох аж. Иргэд дээрэм, танхай, хулгай гээд орчиндоо аюул учруулж болзошгүй зүйлийн мэдээллийг гар утаснаасаа видео, зураг хэлбэрээр аппликейшн рүү хийж, цагдаагийн байгууллагад мэдээлэх юм байна. Энэ дагуу цагдаагийн байгууллагынхан шуурхай ажиллах, таслан зогсоох, хэрэгтнийг барих нөхцөл бүрдэх гэнэ.

Авто угаалгын газруудыг хоёр сая 880 мянган төгрөгөөр торгов

Нийслэлийн мэргэжлийн хяналтын Байгаль орчин, геологи, уул уурхайн хяналтын хэлтсийн улсын байцаагчид Нийслэлийн удирдах зөвлөгөөнөөс өгсөн үргийн дагуу Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын дэд даргын баталсан тавдугаар сарын 03-ны өдрийн 02-03/338 тоот "Төлөвлөгөөт бус шалгалт хийх тухай" удирдамжийн хүрээнд төвийн зургаан дүүргийн авто замын дагуу үйл ажиллагаа явуулж байгаа авто машины угаалгын газруудад шалгалт хийжээ. Шалгалтад авто замын дагуу байрлалтай нийт 80 авто машины угаалгын газар хамрагдсан байна. Шалгалтын явцад байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийлгээгүй, ус ашиглах дүгнэлт гаргуулаагүй, хог хаягдал тээвэрлүүлэх гэрээ хийгээгүй, ойр орчиндоо мод тарьж, зүлэгжүүлэлт хийгээгүй, авто машины угаалгын үйлчилгээ ангилал, ерөнхий шаардлага MNS 5347:2003 стандартын зарим хэсгийг зөрчсөн зэрэг нийтлэг зөрчлүүд илэрсэн аж. Зөрчил гаргасан иргэн, аж ахуйн нэгжүүдэд нийт хоёр сая 880 мянган төгрөгийн торгууль ногдуулж, 67 авто угаалгын газрын эздэд нийт 261 заалт бүхий "Зөрчил арилгуулах тухай" улсын байцаагчийн хугацаатай албан шаардлага хүргүүлж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллажээ.

СЭРЭМЖЛҮҮЛЭГ

Эцэг эхчүүдэд машиндаа хүүхдийн суудал авахыг анхаарууллаа

Урин дулаан цаг ирсэнтэй холбогдуулан гэр бүлээрээ амралт, зугаалганд явах иргэдийн тоо ихэсдэг байна. Иргэд машинд суухдаа бага насны хүүхдээ өвөр дээрээ авч суух, хамгаалалтын бүс байхгүйгээр суулгах зэрэг зөрчлийг гаргадаг аж. Үүнтэй холбогдуулан Замын цагдаагийн газраас хүүхдүүддээ зориулж хамгаалалтын суудлыг хэрэглэхийг анхаарууллаа.

PHOTO NEWS



Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдөр өмчдөр болоо. Энэхүү өдрийг манай улс 64 дэх удаагаа тэмдэглэж байгаа юм. Тус өдрийг тохиолдуулан "Нол", "Авьяас", "Багшийн хөгжил" хөтөлбөрийн үр дүнг олон нийтэд тайлагнах, баян, хүүхдийн авьяас, үр чадвар, алжилтыг сурталчлаа, алдаршуулах зэрэг олон үйл ажиллагаа боллоо.



ЗАВСАРЛАГА

МОНГОЛД АНХ УДАА "СҮҮНИЙ ӨДӨР"-ИЙГ ТЭМДЭГЛЭЛЭЭ

Ж.МЯГМАР

НУБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллагын санаачлагаар 2001 оноос жил бүрийн тавдугаар сарын 31-ний өдрийг Дэлхийн сүүний өдөр болгон зарлаж, тэмдэглэсээр ирсэн. Харин Монгол Улсад анх удаа энэ өдрийг өнгөрөгч мягмар гарат "Чингисийн талбай"-д тэмдэглэн өнгөрүүлээ. Энэ өдрийг дэлхий нийтээр 16 дахь жилдээ тэмдэглэж байгаа бол манай улс анх удаагаа "Эх орны сүү, эрүүл хүнс, амьдралын баталгаа" уриан дор тэмдэглэв. Сүү, сүүн бүтээгдэхүүний хэрэглээнд олон нийтийн анхаарлыг хандуулах, сүүний салбарын хөгжлийг дэмжих, хамтын ажиллагааг бэхжүүлэх зорилгоор энэ өдрийг зохион байгуулж байгаа гэдгийг албаныхан онцолж буй. Сүүний өдөрлөгт нийслэлийн Захирагчийн алба, "Глобал Коммунитис" ОУБ-ын "EMERGE" хөтөлбөр, МХЕГ, Монголын хүнсчдийн холбоо, Монголын эмэгтэй скаутын холбоо, Монсүү, "Сүү", "АПУ", "ТЕСО-Милко", "Витафит инвест" ХХК, "Сүүтэй Монгол" ТББ зэрэг компаниуд оролцож сүү сүүн бүтээгдэхүүний ашиг тусын талаар олон нийтэд мэдээлэл өгч, өөрсдийн нэрийн бүтээгдэхүүнийг хямдралтай үнээр худалдаалаа.

Энэхүү арга хэмжээг нээж ХХАА-н сайд Р.Бурмаа хэлсэн үгэндээ "Монгол



Улсын Хүнсний тухай хуулиар сүүг стратегийн хүнсний ангилалд оруулснаар хуурай сүүний импортод хязгаарлалт хийх, сүү боловсруулах үйлдвэр, цехэд техникийн зохицуулалтын шаардлагад нийцсэн түүхий сүүг нийлүүлсэн малчин, эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчид мөнгөн урамшуулал олгож болох эрх зүйн орчин бүрдсэн. Мөн Засгийн газрын үнэт цаас арилжаалж бүрдүүлсэн хөрөнгөөс 2012-2015 оны хооронд сүү үйлдвэрлэгч, боловсруулагч нийт 47 аж

ахуйн нэгжид 38.4 тэрбум төгрөг, "Сүүний чиглэлийн үхрийн цогцолбор аж ахуйг шинээр байгуулах, өргөжүүлэх"-д зориулж 74 аж ахуйн нэгжид 1.6 тэрбум төгрөгийн зээлийг тус тус олгож, бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэхэд хөрөнгө оруулалтын дэмжлэг үзүүлж ажиллалаа. Цаашид сүү сүүн бүтээгдэхүүний хэрэглээг нэмэгдүүлэх, мөн "Сурагчийн үдийн цай" хөтөлбөрийн бүтээгдэхүүний 60 хүртэлх хувийг сүү сүүн бүтээгдэхүүн болгох, техникийн шаардлага

...Монгол Улсын сүүний хэрэглээ жилээс жилд өсөн нэмэгдэж байна. ...

хангасан сүүг үйлдвэр цехэд нийлүүлж байгаа малчин, фермерт урамшуулал олгох гэх мэт тодорхой ажлуудыг зохион байгуулах бодлого баримталж байна" хэмэсэн юм. Мөн өдөрлөгт оролцогчдын шүд болон биен дэх кальцийн хэмжээг тогтоох, ясны сийрэгжилтийг оношлох зэрэг үнэ төлбөргүй эрүүл мэндийн үзлэг зөвлөгөөг өгсөн юм. Ер нь сүүний хэрэглээ жилээс жилд нэмэгдэж байгаа. Тиймээс ч иргэд өдөр тутамдаа цэвэр сүү, сүүн бүтээгдэхүүнийг

олон төрлөөр хэрэглэх хэрэгцээ, шаардлага бий болж байна. Ялангуяа хүүхдийн сүүний хэрэглээг нэмэх нь чухал байгаа юм. Энэ талаар Сүүний салбарыг хөгжүүлэх үндэсний зөвлөлийн гүйцэтгэх захирал Д.Мөнхжаргал "Дэлхийн сүүний өдрийг бид анх удаа тэмдэглэж байна. Өдөрлөгт сүүний салбарт ажиллаж байгаа 100 гаруй аж ахуйн нэгж оролцож байгаа. Монгол Улсын сүүний хэрэглээ жилээс жилд өсөн нэмэгдэж байна. Өөрөөр хэлбэл, зөвхөн цай сүлэх сүү, уламжлалт ааруул, хурууд гэхээс илүү Монгол Улсын хүн ам залуужиж байгаа учир өдөр тутамдаа сүү, тараг ууж хэвшээд байгаа. Энэ бол маш чухал зөв хэвшил юм. Түүнчлэн үйлдвэрийн аргаар боловсруулсан сүүг сургуулийн хүүхдийн үдийн цай хөтөлбөрт өгөх үйл ажиллагааг Засгийн газраас ач холбогдол өгч дэмжиж байна. Тиймээс сургуулийн бага болон дунд ангийн хүүхдүүд сүү, сүүн бүтээгдэхүүн ийнхүү хэрэглэснээр сургуулиа төгсөөд амьдарлын идэвхитэй үйл ажиллагаанд шилжин ороход ямар нэгэн эрдсийн дутагдалгүй байна гэсэн үг. Түүнчлэн ясны сийрэгжилт, болон кальцийн дутагдалгүй байх болно. Тиймээс ч сүү, сүүн бүтээгдэхүүнийг нийт монголын ард түмэн өргөнөөр хэрэглэхийг уриалмаар байна" гэв.